



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
О.НОМИНЧИМЭГ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.05.08 № ХЭГ/1542  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Асуултын хариу хүргүүлэх тухай

Таны 2026 оны 20 дугаартай албан бичгээр ирүүлсэн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын гэрээ хэлэлцээрийн талаарх асуултад дараах хариуг хүргүүлж байна:

**1 дүгээр асуултын хүрээнд:**

Улсын Их Хурлаас 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэлийг баталж, 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай хэлэлцээр"-ийг соёрхон баталсан бөгөөд дипломат шугамаар ноот бичиг солилцон 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр хэлэлцээр хүчин төгөлдөр болсон.

Тус хэлэлцээрийн дагуу Зам, тээврийн яам болон харьяа байгууллагын зүгээс дараах хэлэлцээр, гэрээг байгуулсан. Үүнд:

-Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын гүүрийг хамтран барих тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан.

-“Тавантолгой төмөр зам” ХХК болон БНХАУ-ын “Чайна энерги ганцмод төмөр замын хөрөнгө оруулалт” ХХК хоорондын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам барих тухай хэлэлцээр"-ийг 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан.

-“Тавантолгой төмөр зам” ХХК болон “Хятадын төмөр замын барилгын гүүрийн инженер товчоо групп” ХХК хооронд байгуулсан “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэх гэрээ”-г 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан.

Дээр дурдсан хэлэлцээр, гэрээг төрийн болон албаны нууцад хамааруулаагүй байна.

"Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай хэлэлцээр"-ийн дагуу "Эрдэнэс Тавантолгой" ХК болон "Чайна энерги хөрөнгө оруулалтын корпораци (мөн түүний хамаарал бүхий этгээд)-тай "Уурхайн хүчин чадал нэмэгдүүлэх хамтын ажиллагааны ерөнхий гэрээ", "Нүүрс худалдах, худалдан авах гэрээ", "Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын санхүүжилтийн гэрээ"-г байгуулсан байх бөгөөд мөн төрийн болон албаны нууц, байгууллагын нууцад хамааруулаагүй болно.

Тагнуулын ерөнхий газраас өгсөн мэдээллээр "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн дагуу хийгдсэн холбогдох гэрээг төрийн болон албан нууцад хамааруулсан талаар Засгийн газраас шийдвэр гарч байгаагүй, мөн тагнуулын байгууллагаас нууцад хамаарах талаар дүгнэлт гаргаж байгаагүй байна.

Мөн Зам, тээврийн яамны 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 01/617, Гадаад харилцааны яамны 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 02/6013 дугаартай албан бичгээр дээрх хэлэлцээр төрийн болон албаны нууцад хамаарах эсэх талаар зөвлөмж хүссэн байх бөгөөд Тагнуулын ерөнхий газрын 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн ТЕГ01/87, 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн ТЕГ01/09 дугаартай албан бичгээр Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг болон Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт"-д хамаарахгүй тухай хариу өгсөн байна.

"Төрийн нууцад хамаарах мэдээллийг ил болгох тухай" Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 123 дугаар тогтоолоор Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанд танилцуулсан Гашуунсухайт-Ганцмод хилийн төмөр замын асуудалтай холбоотой 27 (хорин долоо) хуудас баримт, Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанд танилцуулсан "Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалт барих болон нүүрс худалдах, худалдан авах гэрээ байгуулах талаар хамтран ажиллах ерөнхий хэлэлцээр"-ийн төсөлтэй холбоотой 33 (гучин гурав) хуудас баримт бичгийг тус тус Тагнуулын ерөнхий газрын саналыг үндэслэн төрийн нууцаас гаргаж, ил болгосон бөгөөд төрийн нууцаас гаргаж, ил болгосон мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн хамгаалалтаас гаргахыг даалгасны дагуу хэрэгжилтийг хангуулсан.

Засгийн газрын мөн өдрийн хуралдаанаас Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам барих болон нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээний төсөл, ерөнхий нөхцөл болон уг асуудлаар "Эрдэнэс Тавантолгой" ХК, "Тавантолгой төмөр зам" ХХК, БНХАУ-ын "Чайна энерги" компани хооронд хийсэн яриа хэлэлцээтэй холбогдох албаны нууцад хамаарах баримт бичгийг хуульд заасан журмын дагуу ил болгох ажлыг зохион байгуулахыг холбогдох албан тушаалтнуудад даалгасны дагуу ил болгосон болно.

**2 дугаар асуултын хүрээнд:**

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар нээлттэй хэлэлцүүлж, 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр соёрхон баталсан бөгөөд "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2025 оны 15 (1360) дахь дугаарын 795-799 дүгээр талд бүрэн эхээр нь нийтэлсэн.

"Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай хэлэлцээр"-ийн I.Нэр томьёо заалтын II-т "Энэхүү хэлэлцээрт тусгагдаагүй аливаа нэр томьёог Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу тайлбарлана. Ойлголтын зөрүүтэй заалтыг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ", VI.Нэмэлт заалтын V-д "Хэлэлцээрийн хэлэлцээ, үнэлгээ болон хэрэгжилтийн явцад нэг талаас нөгөө талдаа дамжуулсан мэдээллийг талууд зөвхөн дотоод хэрэгцээндээ ашиглах бөгөөд нөгөө талаасаа бичгээр урьдчилан зөвшөөрөл авахгүйгээр аливаа нэг гуравдагч этгээдэд задруулахыг хориглоно. Энэхүү гуравдагч этгээд гэдэгт уг хэлэлцээрийн хүрээнд төмөр замын бүтээн байгуулалт, нүүрсний худалдаа, нүүрсний уурхайн бүтээн байгуулалтын хамтын ажиллагаанд оролцоогүй төрийн байгууллага, аж ахуйн нэгжийг ойлгох бөгөөд тэдгээрээр хязгаарлахгүй" гэж тус тус заасан бөгөөд мөн хэлэлцээрийн хэрэгжилтийг хариуцах байгууллагаар Монголын талаас Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Хятадын талаас Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо гэж тодорхойлсон.

Олон улсын гэрээний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт "Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг гэрээний нөгөө тал, эсхүл бусад тал хэрхэн биелүүлж байгаа, монголын талын эрхийг хэрхэн хангаж байгаад тухайн олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.", 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт "Гадаад харилцааны болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олон улсын гэрээг зөв хэрэглэх талаар зөвлөмж өгч болно." гэж тус тус хуульчилсан.

"Эрдэнэс Тавантолгой" ХК-аас байгуулсан гэрээнүүд, холбогдох баримт бичгийг олон нийтэд ил болгосноор хэлэлцээрийн дээр дурдсан зохицуулалттай зөрчилдөх эсэх асуудалд "тус хэлэлцээртэй холбоотой, хэлэлцээрийн хэлэлцээ, үнэлгээ болон хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг олон нийтэд ил болгох асуудлыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас хэлэлцээрт заасны дагуу хятадын талаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авах, Засгийн газарт танилцуулж шийдвэрлүүлэх нь зүйтэй" гэсэн зөвлөмжийг Гадаад харилцааны яамнаас өгсөн.

Иймд "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай хэлэлцээр"-ийн дагуу байгуулсан гэрээнүүдийг нууцлаагүй бөгөөд холбогдох гэрээнүүдийг олон нийтэд мэдээлэх асуудлыг хэлэлцээрийн хэрэгжилтийг хариуцах байгууллагаас хятадын талтай урьдчилан тохиролцсоны үндсэн дээр хэрэгжүүлэхээр байна.

Түүнчлэн, тус хэлэлцээрийн дагуу байгуулсан холбогдох гэрээнд нууцлалтай мэдээллийг Засгийн газрын эрх бүхий байгууллагаас хүссэн буюу шаардсан тохиолдолд өгч болохоор заасны дагуу Улсын Их Хурлын зарим гишүүдэд “Эрдэнэс Тавантолгой” ХК болон “Чайна Энержи Кокин Коал (Тяньжин)” ХХК-ийн хооронд 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан ”(ЭТТ-2025/288) дугаартай “Нүүрс худалдах, худалдан авах гэрээ”, “Эрдэнэс Тавантолгой” ХК болон “Чайна Энержи Интернейшнл Деволупмент” ХХК-ийн хооронд 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан ”(ЭТТ-2025/289) дугаартай “Уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны ерөнхий гэрээ”, “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой төмөр зам” ХХК болон “Хятадын төмөр замын барилгын гүүрийн инженерийн товчоо групп” компани хооронд 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан ”(ЭТТ-2025/512), СГ-2025/01 дугаартай “Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын санхүүжилтийн гэрээ”-г тус тус хуулбарлан хүргүүлж байсан болно.

Хавсралт 133 хуудастай.



Монгол улсын засгийн газар  
Засгийн газрын хэрэг эрхлэх газар  
Монгол улсын сайд, засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга  
Б.Энхбаяр  
2026.05.08 17:34



МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ

САЙД

Энхтайвны өргөн чөлөө 7а,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210  
Утас: 262135, Факс: (976-11)322127  
Цахим шуудан: info@mfa.gov.mn  
Цахим хуудас: www.mfa.gov.mn

2026.05.07 № 01/2211

танай 2026.05.05 -ны № ХЭГ/1492 -т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА Б.ЭНХБАЯР ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Танай ХЭГ/1492 дугаартай албан бичгээр ирүүлсэн Монгол Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн асуултад дараах хариултыг хүргүүлж байна.

“Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” (цаашид “хэлэлцээр” гэх)-ийг 2025 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталж, дипломат шугамаар ноот бичиг солилцон 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр хэлэлцээр хүчин төгөлдөр болсон.

Тус хэлэлцээрийн төслийг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар нээлттэй хэлэлцүүлж, баталсан бөгөөд “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2025 оны 15 (1360) дахь дугаарын 795-799 дүгээр талд бүрэн эхээр нь нийтэлсэн.

Хэлэлцээрийн VI зүйлийн (V) хэсэгт “...Энэхүү гуравдагч этгээд гэдэгт уг хэлэлцээрийн хүрээнд төмөр замын бүтээн байгуулалт, нүүрсний худалдаа, нүүрсний уурхайн бүтээн байгуулалтын хамтын ажиллагаанд оролцоогүй төрийн байгууллага, аж ахуйн нэгжийг ойлгох бөгөөд тэдгээрээр хязгаарлахгүй” гэж “гуравдагч этгээд”-ийг тодорхой зааж өгсөн.

Хэлэлцээрийн I зүйлийн (II) хэсэгт “Энэхүү хэлэлцээрт тусгагдаагүй аливаа нэр томъёог Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу тайлбарлана. Ойлголтын зөрүүтэй заалтыг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ” гэж заасны дагуу “дамжуулсан

мэдээлэл” гэдэгт хэлэлцээрийн дагуу байгуулсан гэрээнд хамаарах эсэх асуудлыг энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтийг хариуцах байгууллага болох Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас тодруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Мөн Олон улсын гэрээний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт “Гадаад харилцааны болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олон улсын гэрээг зөв хэрэглэх талаар зөвлөмж өгч болно” гэж заасны дагуу бусад шаардлагатай хууль зүйн зөвлөмжийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас авна уу.

Хувийг: АҮЭБЯ, ХЗДХЯ-нд



Гадаад харилцааны яам  
Удирдлага  
Гадаад харилцааны сайд  
Батмөнх БАТЦЭЦЭГ  
2026-05-07 13:43:20



МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА Б.ЭНХБАЯР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН  
АЖ ҮЙЛДВЭР,  
ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД

Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэстний гудамж 5/1,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: (976-51) 26 35 06,  
Цахим шуудан: info@mimr.gov.mn,  
Цахим хуудас: www.mimr.gov.mn

2026.05.08 № 01 | 1455  
танай 2026.04.24 -ны № ам | 1346 -т

Хариу хүргүүлэх тухай

Танаас ирүүлсэн 2026 оны хэг/1346 дугаартай Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн асуулт хүргүүлэх тухай албан бичигтэй танилцлаа.

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны хэлэлцээр"-т талууд 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр гарын үсэг зурж, Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы 2025 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар соёрхон баталсан.

Уг хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Төслийн хэрэгжилттэй холбоотой түүхэн нөхцөл байдлыг харгалзан төслийг цаашид саадгүй хэрэгжүүлэх зорилгоор Талуудын холбогдох аж ахуйн нэгжүүд энэхүү Хэлэлцээрийн хүрээнд үйл ажиллагаагаа эрчимжүүлнэ. Холбогдох аж ахуйн нэгжүүдэд дор дурдсан аж ахуйн нэгжийг хэлэх бөгөөд түүгээр хязгаарлахгүй; Монголын талаас: "Эрдэнэс Тавантолгой" ХК (Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж) болон түүний хамаарал бүхий хуулийн этгээдүүд гэж заасан байдаг.

Дээрх заалтын хүрээнд аж ахуйн нэгжийн хооронд байгуулсан гэрээг тус яам хариуцдаггүй бөгөөд албан бичигт дурдсан асуудлыг "Эрдэнэс Тавантолгой" ХК хариуцдаг болно.

Хавсралтаар Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хүргүүлж байна.

Жич: Уг хэлэлцээрийн VI зүйлийн V хэсэгт "Хэлэлцээрийн хэлэлцээ, үнэлгээ болон хэрэгжилтийн явцад нэг талаас нөгөө талдаа дамжуулсан мэдээллийг Талууд зөвхөн дотоод хэрэгцээндээ ашиглах бөгөөд нөгөө талаасаа бичгээр урьдчилан зөвшөөрөл авахгүйгээр аливаа гуравдагч этгээдэд задруулахыг хориглоно" гэж заасан байгааг анхаарна уу.

Хавсралт 5 хуудастай.



Г.ДАМДИННЯМ

d:\ayэбя 2026 Сайд А4.docx

1508 09 0278



**ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД БООМТЫН ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР ЗАМ,  
НҮҮРСНИЙ ХУДАЛДАА, ТАВАНТОЛГОЙН НҮҮРСНИЙ УУРХАЙН ХҮЧИН  
ЧАДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ  
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН  
БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР  
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

“Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоох тухай Хамтарсан тунхаглал”-д үндэслэж,

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар (цаашид хамтад нь “Талууд”, тусад нь “хятадын тал”, “монголын тал” гэх) нь,

Хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдлөг болгож,

Харилцан ашигтай, эрх тэгш, аж ахуйн нэгжийн манлайллыг дэмжсэн, зах зээлийн үйл ажиллагаа болон олон улсын туршлагад нийцсэн зарчмыг тус тус баримталж,

“Гурвыг цогцоор” зарчимд тулгуурлаж “Гашуунсухайт-Ганцмод” боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалт, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааг хэрэгжүүлэхээр хэлэлцэн тохиролцов.

## **I. НЭР ТОМЬЁО**

- (I) Энэхүү хэлэлцээрт дурдсан дараах нэр томьёог дор дурдсанаар ойлгоно:

“Гурвыг цогцоор” гэж Талуудад тогтвортой, урт хугацааны эдийн засгийн үр өгөөжтэй байх нөхцөлийг бүрдүүлэх “Гашуунсухайт-Ганцмод” боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэлнэ. Хоёр улсын аж ахуйн нэгж тус бүр зах зээлийн зарчимд үндэслэн нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны харилцан ашигтай гэрээг байгуулна. Эдгээр гэрээ нь ашигт малтмалын тогтвортой нийлүүлэлтийг хангах зорилгоор Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэхтэй холбоотой цогц арга хэмжээг агуулна.

(II) Энэхүү хэлэлцээрт тусгагдаагүй аливаа нэр томъёог Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу тайлбарлана. Ойлголтын зөрүүтэй заалтыг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

## **II. ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАРИУЦАХ БАЙГУУЛЛАГА**

(I) Талууд энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилтийг хариуцах дараах байгууллагыг тодорхойлов. Үүнд:

Монголын талаас: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам  
Хятадын талаас: Үндэсний хөгжил, шинэчлэлийн хороо

(II) Төслийн хэрэгжилттэй холбоотой түүхэн нөхцөл байдлыг харгалзан төслийг цаашид саадгүй хэрэгжүүлэх зорилгоор Талуудын холбогдох аж ахуйн нэгжүүд энэхүү Хэлэлцээрийн хүрээнд үйл ажиллагаагаа эрчимжүүлнэ. Холбогдох аж ахуйн нэгжүүдэд дор дурдсан аж ахуйн нэгжийг хэлэх бөгөөд түүгээр хязгаарлахгүй:

Монголын талаас: “Эрдэнэс Тавантолгой” ХК (төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж) болон түүний хамаарал бүхий хуулийн этгээдүүд байна.

Хятадын талаас: “Чайна Энержи хөрөнгө оруулалтын корпорац” (төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж) болон түүний хамаарал бүхий хуулийн этгээдүүд, эсхүл “Чайна Энержи хөрөнгө оруулалтын корпорац”, түүний хамаарал бүхий хуулийн этгээдтэй хамтран ажилладаг хятадын санхүүжилттэй байгууллага, аж ахуйн нэгж байна.

## **III. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ХҮРЭЭ**

Талууд “Гурвыг цогцоор” хамтын ажиллагааны зарчмыг хэрэгжүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэхийн тулд дараах гурван цогц арга хэмжээг дэмжинэ. Үүнд:

### **(I) Хил дамнасан төмөр замыг хамтран барих**

1. Талууд “барилгын ажлын нарийвчилсан төлөвлөгөө, стандарт зэрэг холболтын ажлыг хамтран гүйцэтгэх, өөр өөрийн нутаг дэвсгэр дэх төмөр замын санхүүжилтийг талууд өөрсдөө хариуцах, төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг зэрэг дуусгах” зарчмыг баримтална. Талууд 2024 оны 4 дүгээр сард байгуулсан “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын гүүрэн байгууламжийг хамтран барих тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн дагуу тус тусын нутаг дэвсгэр дээрх төмөр зам, боомтын бүтээн байгуулалт болон хөрөнгө оруулалтын асуудлыг өөрсдөө хариуцна. Талууд тус тусын төмөр замын

царигийн стандарт болон дүрэм, журмыг дагаж мөрдөнө. Аж ахуйн нэгж хооронд бүтээн байгуулалтын ажлын гэрээнд гарын үсэг зурах, төслийг эхлүүлэх хугацааны талаар харилцаа холбоог хадгалахад дэмжлэг үзүүлж, бүтээн байгуулалтын ажлыг аль болох эрт эхлүүлэхийг эрмэлзэнэ. Аж ахуйн нэгж хооронд нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээ болон Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэхтэй холбоотой хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурах нь хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх урьдач нөхцөл болно.

2. Талууд өөр өөрийн нутаг дэвсгэрт төмөр замын бүтээн байгуулалтын чанарт тавих хяналтыг хариуцах бөгөөд хил холболтын хэсгийн чанарын хяналтыг хамтдаа хариуцна.

3. Талууд энэхүү төмөр замыг хил дамнасан нүүрс тээвэрлэлтэд түлхүү ашиглахыг дэмжиж, хоёр улсын аж ахуйн нэгжүүд хооронд худалдсан нүүрсийг уг төмөр замаар тэргүүн ээлжид тээвэрлэнэ.

### **(II) Нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээ**

Талууд "Гашуунсухайт-Ганцмод" төмөр зам болон хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалт удааширсан, Талуудад учирсан цаг хугацаа болон эдийн засгийн алдагдал, хоёр талын хооронд өмнө нь байгуулж байсан нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээний жишиг зэргийг харгалзан үзэж, харилцан зөвшилцөх замаар хоёр улсын аж ахуйн нэгжүүд "Эрдэнэс Тавантолгой" ХК болон Хятадын төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн хооронд байгуулсан нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээний хамгийн сүүлд баталгаажсан үнэ (энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурах өдрөөс өмнөх) анхны үнэ болгох (FCA-нүүрс нийлүүлэх цэг нь Тавантолгойн уурхайн талбай)-оор тохиролцсон бөгөөд дараагийн үнийг талуудын харилцан зөвшилцсөн механизм буюу "анхны үнэ + хамтран сонгож авсан улирлын индексийн тохируулга"-аас гаргана. Нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээнд нүүрсний чанар, хэмжээ, хугацааг тохирч хэлэлцээрт тохирсон үнийн аргачлалыг баримтална.

### **(III) Нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх**

1. Хил дамнасан төмөр замын тээврийн хэмжээ, эдийн засаг, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг урт хугацаанд хангах, төмөр замаар тээвэрлэх ачаа тээврийн хэмжээг баталгаажуулах зорилгоор Монголын тал "Эрдэнэс-Тавантолгой" ХК Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадал, нүүрс олборлолтын хэмжээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Талууд шинээр уурхайн талбайг хөгжүүлэх, олборлолтын үйл ажиллагааг эхлүүлэх зорилгоор Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх бүтээн байгуулалтын

хамтын ажиллагаанд энэхүү гэрээний II зүйлийн (II) дахь хэсэгт заасан аж ахуйн нэгжүүдийг арилжааны зарчмаар оролцохыг дэмжиж, хамтран ажиллана.

2. Эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хүрээнд хайгуул, төлөвлөлт, олборлолтын явцад орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, байгаль орчинд ээлттэй, бүтээмж өндөртэй үйл ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөлийг хангана.

#### **IV. ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ**

(I) Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлснээр "Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоох тухай Хамтарсан тунхаглал"-ын хүрээнд "Гашуунсухайт- Ганцмод" боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

(II) Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх хугацаанд, хоёр улсын аж ахуйн нэгж хооронд хэлэлцээрийн үр дүнг хамтын ажиллагааны чиглэл бүрээр дүгнэж, цаашид хамтран хэрэгжүүлэх арга хэмжээг цаг хугацаанд нь төлөвлөнө.

(III) Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх хугацаанд, хоёр улсын аж ахуйн нэгж хооронд уг хэлэлцээрийн хүрээнд нүүрс худалдах, худалдах авах урт хугацааны гэрээ шинээр байгуулах нь хоёр улсын аж ахуйн нэгж хооронд өмнө нь байгуулсан нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээний биелэлтэд нөлөөлөхгүй.

#### **V. БУСАД**

Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш Талууд хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын бусад төсөл болон эрчим хүчний нүүрсний экспортыг идэвхтэй урагшлуулна. Талууд хот байгуулалт, орон сууцжуулалт болон дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана. Талууд боомтуудын хамтын ажиллагааг бэхжүүлж, гаалийн нэвтрүүлэх чадавхыг нэмэгдүүлнэ. Талууд аж ахуйн нэгжүүдийг арилжааны зарчмаар сэргээгдэх эрчим хүчтэй холбоотой хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд үргэлжлүүлэн дэмжинэ.

#### **VI. НЭМЭЛТ ЗААЛТ**

(I) Талууд өөрсдийн дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангаснаар энэхүү Хэлэлцээр нь хүчин төгөлдөр болох бөгөөд 16 жилийн хугацаанд хүчинтэй байна. Аль нэг тал энэхүү хэлэлцээрийг цуцлах тохиолдолд дипломат шугамаар нөгөө талдаа энэ талаар бичгээр мэдэгдэж, нөгөө талын зөвшөөрлийг авна. Хэлэлцээрийг цуцлах гэж буй тал нөгөө талын зөвшөөрлийг авснаас хойш зургаан сарын дараа хэлэлцээр цуцлагдана. Хэлэлцээрийг цуцалснаар уг хэлэлцээрийг

хүчин төгөлдөр үйлчилж байх хугацаанд хэрэгжүүлсэн хамтын ажиллагаа болон хэлэлцээрийн хүрээнд Талуудын аж ахуйн нэгж хооронд байгуулсан гэрээний үйлчлэлд тус тус нөлөөлөхгүй.

(II) Талууд хооронд хэлэлцүүлж, харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.


(III) Талууд энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх болон тайлбарлахтай холбоотой аливаа маргааныг найрсгаар харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.


(IV) Талууд энэхүү хэлэлцээрийн холбогдох заалтууд болон уг хэлэлцээрийн хүрээнд байгуулсан аж ахуйн нэгж хоорондын гэрээг чандлан биелүүлнэ.

(V) Хэлэлцээрийн хэлэлцээ, үнэлгээ болон хэрэгжилтийн явцад нэг талаас нөгөө талдаа дамжуулсан мэдээллийг Талууд зөвхөн дотоод хэрэгцээндээ ашиглах бөгөөд нөгөө талаасаа бичгээр урьдчилан зөвшөөрөл авахгүйгээр аливаа нэг гуравдагч этгээдэд задруулахыг хориглоно. Энэхүү гуравдагч этгээд гэдэгт уг хэлэлцээрийн хүрээнд төмөр замын бүтээн байгуулалт, нүүрсний худалдаа, нүүрсний уурхайн бүтээн байгуулалтын хамтын ажиллагаанд оролцоогүй төрийн байгууллага, аж ахуйн нэгжийг ойлгох бөгөөд тэдгээрээр хязгаарлахгүй. Хэлэлцээрийн бусад заалтад нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах эсхүл дуусгавар болгох нь уг нөхцөлийн үйлчлэлд үл нөлөөлнө.


Энэхүү хэлэлцээрийг 2025 оны 2 сарын 14-ний өдөр Харбин хотноо монгол, англи, хятад хэлээр үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Ойлголтын зөрүү гарсан тохиолдолд англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:

  
ЦЭВЭГДОРЖИЙН ТУВААН

  
БОРХҮҮГИЙН ДЭЛГЭРСАЙХАН

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:

  
ЖӨН ШАНЬЖЕ



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ  
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв  
Утас: 7505-5555

И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.ett.mn

᠒᠐᠒᠖. 04. ᠒9 № 01/᠑᠒7

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА Б.ЭНХБАЯР ТАНАА**

**Мэдээлэл хүргүүлэх тухай**

БНХАУ-ын Харбин хотноо 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр байгуулагдсан "Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын "Гашуунсухайт-Ганцмод" боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны хэлэлцээр"-ийг Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Соёрхон баталсан.

Соёрхон баталсан тус хэлэлцээрийн "VI. Нэмэлт заалт"-ын (V)-д "Хэлэлцээрийн хэлэлцээ, үнэлгээ болон хэрэгжилтийн явцад нэг талаас нөгөө талдаа дамжуулсан мэдээллийг Талууд зөвхөн дотоод хэрэгцээндээ ашиглах бөгөөд нөгөө талаасаа бичгээр урьдчилан зөвшөөрөл авахгүйгээр аливаа нэг гуравдагч этгээдэд задруулахыг хориглоно. Энэхүү гуравдагч этгээд гэдэгт уг хэлэлцээрийн хүрээнд төмөр замын бүтээн байгуулалт, нүүрсний худалдаа, нүүрсний уурхайн бүтээн байгуулалтын хамтын ажиллагаанд оролцоогүй төрийн байгууллага, аж ахуйн нэгжийг ойлгох бөгөөд тэдгээрээр хязгаарлахгүй..." гэж заасан.

"Эрдэнэс Тавантолгой" ХК болон "Чайна энерги хөрөнгө оруулалтын корпораци (мөн түүний хамаарал бүхий этгээд)-тай байгуулсан "Уурхайн хүчин чадал нэмэгдүүлэх хамтын ажиллагааны ерөнхий гэрээ", "Нүүрс худалдах, худалдан авах гэрээ", "Гашуунсухайт-Ганцмод" хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын санхүүжилтийн гэрээ", түүний холбогдох баримт бичгийг олон нийтэд ил болгосноор хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дээрх заалт зөрчигдөх үр дагавартай болно.

Иймд "Эрдэнэс Тавантолгой" ХК-иас Гадаад харилцааны яаманд хандан 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр 02/2514 дугаартай албан бичгээр хоёр улсын хэлэлцээр болон хууль тогтоомжийг үндэслэн байгуулсан "Гашуунсухайт-Ганцмод" хил дамнасан төмөр зам барихтай холбоотой гэрээ, Талуудын уулзалтын тэмдэглэл, ажлын хэсгийн тайлангаас задруулахыг хориглосон, эсвэл аль нэг хэсгийг ил болгох талаар зөвлөмж, чиглэл өгөхийг хүссэн албан бичиг хүргүүлсэн.

Гадаад харилцааны яамнаас 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 03/4978 дугаартай албан бичгээр "тус хэлэлцээртэй холбоотой, хэлэлцээрийн хэлэлцээ, үнэлгээ болон хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг олон нийтэд ил болгох асуудлыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас хэлэлцээрт заасны дагуу хятадын талаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авах, Засгийн газарт танилцуулж шийдвэрлүүлэх нь зүйтэй" талаар хариуг ирүүлж, хувийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд түүгээр хүргүүлсэн болно.

1526041849

Дээрх зөвлөмжийн дагуу хятадын талтай зөвшилцсөн эсэх болон Засгийн газраас холбогдох шийдвэр гарсан эсэх талаар мэдээлэл, чиглэл "Эрдэнэс Тавантолгой" ХК-д одоогоор ирээгүй байгаа тул хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн зохицуулалтыг компани мөрдөн ажиллаж байна.

Дээр дурдсан хэлэлцээр болон хэлэлцээрийн хүрээнд байгуулагдсан гэрээнүүдийг нь Монгол Улсын төрийн байгууллагаас "төрийн болон албаны нууц"-д хамааруулаагүй бөгөөд "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьд мөн адил байгууллагын нууцад хамааруулаагүй болно.

Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Соёрхон баталсан олон улсын гэрээний үүргийг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн зүгээс биелүүлсэн бөгөөд Олон улсын гэрээний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг "Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг гэрээний нөгөө тал, эсхүл бусад тал хэрхэн биелүүлж байгаа, монголын талын эрхийг хэрхэн хангаж байгаад тухайн олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина" гэж заасны дагуу тус хэлэлцээрт Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Зам тээврийн яам хяналт тавих зохицуулалттай болохыг үүгээр уламжилж байна.

Дашрамд дурдахад, Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн албан бичгийн дагуу "Уурхайн хүчин чадал нэмэгдүүлэх хамтын ажиллагааны ерөнхий гэрээ", "Нүүрс худалдах, худалдан авах гэрээ", "Гашуунсухайт-Ганцмод" хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын санхүүжилтийн гэрээ"-ний хуулбарыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраар дамжуулан тухай бүр хүргүүлж байсан болно.

Хавсралт 3 хуудастай.

1. "Эрдэнэс Тавантолгой" ХК-иас Гадаад харилцааны яаманд хүргүүлсэн 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 02/2514 дугаартай "Зөвлөмж хүсэх тухай" албан бичиг,

2. Гадаад харилцааны яамнаас "Эрдэнэт Тавантолгой" ХК-д ирүүлсэн 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 03/4978 дугаартай "Хариу хүргүүлэх тухай" албан бичиг.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Н.ЦЭРЭНСАМБУУ



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ  
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
1 дугаар хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв  
Утас: 7505-5555

И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.ett.mn

2025.10.09 № 02/2514

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМАНД

**Зөвлөмж хүсэх тухай**

Монгол Улсын Засгийн 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн "Төрийн нууцад хамаарах мэдээллийг ил болгох тухай" тогтоолоор "Гашуунсухайт-Ганцмод" хил дамнасан төмөр зам барихтай холбоотой гэрээ, холбогдох баримт бичгийг ил болгохоор шийдвэрлэсэн

БНХАУ-ын Харбин хотноо 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн "VI. Нэмэлт заалт"-ын (V)-д "Хэлэлцээрийн хэлэлцээ, үнэлгээ болон хэрэгжилийн явцад нэг талаас нөгөө талдаа дамжуулсан мэдээллийг Талууд зөвхөн дотоод хэрэгцээндээ ашиглах бөгөөд нөгөө талаасаа бичгээр урьдчилан зөвшөөрөл авахгүйгээр аливаа нэг гуравдагч этгээдэд задруулахыг хориглоно. Энэхүү гуравдагч этгээд гэдэгт уг хэлэлцээрийн хүрээнд төмөр замын бүтээн байгуулалт, нүүрсний худалдаа, нүүрсний уурхайн бүтээн байгуулалтын хамтын ажиллагаанд оролцоогүй төрийн байгууллага, аж ахуйн нэгжийг ойлгох бөгөөд тэдгээрээр хязгаарлахгүй..." гэж заасан.

Монгол Улсын Их хурлаас 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны хэлэлцээр"-ийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсан.

"Эрдэнэс Тавантолгой" ХК болон БНХАУ-ын Чайна Энержи хөрөнгө оруулалтын корпорац (мөн түүний хамаарал бүхий этгээдтэй)-тай байгуулсан "Уурхайн хүчин чадал нэмэгдүүлэх хамтын ажиллагааны ерөнхий гэрээ", "Нүүрс худалдах, худалдан авах гэрээ", "Гашуунсухайт-Ганцмод" хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын санхүүжилтийн гэрээ", түүний холбогдох баримт бичгийг олон нийтэд ил нийтлэх нь хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дээрх заалт болон Соёрхон баталсан хуулийг зөрчсөн үйлдэл болохоор байна

Хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг хариуцах байгууллагаар Монголын талаас Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Хятадын талаас Үндэсний хөгжил шинэчлэлийн хороог тодорхойлсон тул Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор өгсөн үүргийн хүрээнд Үндэсний хөгжил шинэчлэлийн хорооноос урьдчилан бичгээр зөвшөөрөл авах шаардлага үүсээд байна.

Иймээс, хоёр улсын хэлэлцээр болон хууль тогтоомжийг үндэслэн байгуулсан "Гашуунсухайт-Ганцмод" хил дамнасан төмөр зам барихтай холбоотой

1125044475

гэрээ, Талуудын уулзалтын тэмдэглэл, ажлын хэсгийн тайлангаас олон нийтэд мэдээлэл болгон бүрэн хэмжээнд гаргах эсхүл товч агуулгаар оруулах эсэх талаар зөвлөмж, чиглэл өгөхийг хүсье.

Хувийг: Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамд

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН  
ГАЗРЫН ДАРГА



Э.БАТБАЯР



МОНГОЛ УЛСЫН  
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

Энхтайваны өргөн чөлөө 7а  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210  
Утас 26 21 35. Факс (976-11) 32 21 27.  
Цахим шуудан: info@mfa.gov.mn  
Цахим хуудас: www.mfa.gov.mn

Хол. 02.14 № 03/4978

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хариу хүргүүлэх тухай

Танай 02/2514 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлттэй танилцаад дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Энэ оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж буй "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн хэрэгжилтийг хангах байгууллагаар монголын талаас Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, хятадын талаас Үндэсний хөгжил, шинэчлэлийн хороог тус тус тодорхойлсон.

Мөн Олон улсын гэрээний тухай хуулийн 24.4-т зааснаар олон улсын гэрээгээр Монгол Улсын хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг Засгийн газарт хариуцуулсан байдаг.

Иймд тус хэлэлцээрийн хэрэгжилттэй холбоотой, хэлэлцээрийн хэлэлцээ, үнэлгээ болон хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг олон нийтэд ил болгох асуудлыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас хэлэлцээрт заасны дагуу хятадын талаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авах, Засгийн газарт танилцуулж шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

Энэхүү Засгийн газар хоорондын хэлэлцээрийн зохицуулалтын талаар ойлголтын зөрүү гарсан тохиолдолд англи хэлээрх эх бичвэрийг баримтлана гэдгийг харгалзан үзэхийг зөвлөж байна.

Хувийг: Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Л.МӨНХТҮШИГ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
**ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**

Жуулчны гудамж-3, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, 15160,  
Утас: 9226 3656, 9226 3017, Факс: (976) 9226 3656,  
Цахим шуудан: info@gia.gov.mn,  
Цахим хуудас: www.gia.gov.mn

2026.05.06 № ТЕГО1/311  
танай 2026.05.05 -ны № ХХ/1491 -Т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА Б.ЭНХБАЯР ТАНАА

### Хариу хүргүүлэх тухай

Танай албан бичигт дурдсан Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгээс тавьсан асуулттай танилцаж тагнуулын байгууллагын чиг үүрэгт хамаарах асуудлаар дараах мэдээллийг хүргүүлж байна.

"Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн дагуу хийгдсэн холбогдох гэрээг төрийн болон албаны нууцад хамааруулсан талаар Засгийн газраас шийдвэр гарч байгаагүй, мөн тагнуулын байгууллагаас нууцад хамаарах талаар дүгнэлт гаргаж байгаагүй болно.

Түүнчлэн Зам, тээврийн яамны 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 01/617 дугаар албан бичиг, Гадаад харилцааны яамны 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 02/6013 дугаар албан бичгээр дээрх хэлэлцээр нь төрийн болон албаны нууцад хамаарах эсэх талаар зөвлөмж хүссэн бөгөөд тагнуулын байгууллагын 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн ТЕГ01/87, 2026 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн ТЕГ01/09 албан бичгээр уг асуудал нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг болон Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт"-д хамаарахгүй талаар хариу хүргүүлж байсан албан бичгийг үүгээр хүргүүлж байна.

Хавсралт 15 хуудастай.

ДАРГА



П.ОДОНБААТАР

09091781





ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙД С.БЯМБАЦОГТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
**ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Жуулчны гудамж-3, Утас: 9226 3656, 9226 3017,  
Факс: 9226 3656, Вэб хаяг: http://www.gia.gov.mn,  
И-мэйл: info@gia.gov.mn

2023.02.24 № ТEG/01/87  
танай 2023.02.08 -ны № 01/619 -Т




Зөвлөмж хүргүүлэх тухай

Засгийн газрын 2022 оны 449 дүгээр тогтоолоор "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын төслийн ажлыг төрийн нууцаас гаргаж ил болгосон.

Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын төслийн ажлыг нууцад хамааруулах тухай Засгийн газрын тогтоол одоогоор гараагүй байх тул уг төслийн ажил нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйл, "Жагсаалт батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 247 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт"-д хамаарахгүй.

Дээрх төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нууцад хамаарах мэдээллийг зайлшгүй танилцуулах шаардлагатай тохиолдолд тухайн албан тушаалтан, иргэн, гадаад улсын иргэн нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, "Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.2-т заасны дагуу тагнуулын байгууллагын аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж, зөвшөөрөл авсан байх зохицуулалттайг үүгээр зөвлөж байна.

ДАРГА



П.ОДОНБААТАР



ХАРАГТАЙ

ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА П.ОДОНБААТАР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД**

14251 Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, Чингисиин өргөн чөлөө 11  
Утас (976) 51-267168 Факс (976) 11-312315  
E-mail info@mrd.gov.mn, http://www.mrd.gov.mn

2023-02-08 № 01/017

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Чиглэл хүсэх тухай**

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 449 дүгээр тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн ажлыг төрийн нууцаас гаргаж ил болгосон. Тус бүтээн байгуулалтын ажил 2022 оны 09 дүгээр сард нээлт хийж, төмөр замаар туршилтын тээврийг эхлүүлээд байна.

Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд 2022 онд хятадын талтай хил холболтын цэг тохирч, төмөр зам барих асуудлаар харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.

Уг бүтээн байгуулалтын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажлыг ойрын хугацаанд эхлүүлэхээр бэлтгэл хангаж байгаа ба бүтээн байгуулалтын ажил нь Монгол Улсын Хилийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу хилийн зурвас газарт хийгдэнэ.

Хил дамнасан төмөр замын суурь, судалгаа, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажлын үйл явц нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн:

13.1.1.а. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын үзэл баримтлал, номлолын нууцалбал зохих хэсэг;

13.1.1.в. Аливаа улстай харилцах Монгол Улсын чиг бодлого, байр суурийг нарийвчлан илэрхийлсэн мэдээлэл, гадаад орнуудаас итгэмжлэгдсэн байдлаар авсан мэдээлэл;

13.1.2.в. Үндэсний аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой шинжлэх ухаан, технологийн ололт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, судалгааны туршилт, угсралт, төслийн ажил, технологийн тухай мэдээлэл;

13.1.3.д. Батлан хамгаалах болон улсын хил хамгаалах зориулалттай болон энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл агуулсан байр зүйн зураг гэх мэт Төрийн нууцад хамааруулах мэдээлэлтэй танилцах, тэдгээрийг ашиглах шаардлага үүсэхээр байна.

Иймд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын төслийн ажил нь Төрийн болон албаны нууцад хамаарах эсэх талаар яаралтай чиглэл өгч хамтран ажиллана уу.

Бүртгэлийн дугаар: 29  
**ТАГНУУЛЫН  
БАЙГУУЛЛАГЫН АРХИВ  
ХУУЛБАР ҮНЭН**  
Хуулбар олгосон ажилтны гарын үсэг  
2023 оны 02-р сарын 08 ны өдөр.

С.БЯМБАЦОГТ



**МОНГОЛ УЛСЫН  
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ**

Энхтайвны өргөн чөлөө 7а  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210  
Утас: 262136, Факс: (976-11)322127  
Цахим шуудан: info@mfa.gov.mn  
Цахим хуудас: www.mfa.gov.mn

2025.12.18 № 02/6013

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_

ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ  
П.ОДОНБААТАР ТАНАА

**ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР**  
Бүртгэлийн дугаар... 08...  
**ХУУЛБАР ХУВЬ**  
..... *Ахуй, хөдөлмөр, амжилт* .....  
(Албан тушаалын нэр)  
..... *Талар* .....  
(гарын үсэг)(гарын үсгийн тайлал)  
2025 оны 08 дугаар сарын 08

Дүгнэлт гаргуулах тухай

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 58 дугаар тогтоолыг үндэслэн Олон улсын гэрээний тухай хуульд заасан журам, зохицуулалтын дагуу "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр" (цаашид "хэлэлцээр" гэх)-т 2025 оны 2 дугаар сарын 14-ний өдөр гарын үсэг зурж, 4 дүгээр сарын 24-ний өдөр хүчин төгөлдөр болсон.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас тус улсад суугаа Элчин сайдын яамнаас 2025 оны 10 дугаар сарын 9-ний өдөр ирүүлсэн 376/2025 дугаартай ноот бичигт тус хэлэлцээрийн VI нэмэлт заалтын (V)-д "Хэлэлцээрийн хэлэлцээ, үнэлгээ болон хэрэгжилтийн явцад нэг талаас нөгөө талдаа дамжуулсан мэдээллийг Талууд зөвхөн дотоод хэрэгцээндээ ашиглах бөгөөд нөгөө талаасаа бичгээр урьдчилан зөвшөөрөл авахгүйгээр аливаа нэг гуравдагч этгээдэд задруулахыг хориглоно. Энэхүү гуравдагч этгээд гэдэгт уг хэлэлцээрийн хүрээнд төмөр замын бүтээн байгуулалт, нүүрсний худалдаа, нүүрсний уурхайн бүтээн байгуулалтын хамтын ажиллагаанд оролцоогүй төрийн байгууллага, аж ахуйн нэгжийг ойлгох бөгөөд тэдгээрээр хязгаарлахгүй. Хэлэлцээрийн бусад заалтад нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах эсхүл дуусгавар болгох нь уг нөхцөлийн үйлчлэлд үл нөлөөлнө" гэж заасныг монголын талд эргэн сануулж, цаашдаа анхааралдаа авч, хэрэгжүүлэхийг хүссэн.

Иймд Монгол Улсын Их Хурлын 58 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд байгуулсан гэрээ хэлэлцээр, түүний бэлтгэл ажил, аж ахуйн нэгж хоорондын хамтын ажиллагааны гэрээ, баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах, нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хуралд

Улсын Их Хурал  
Хүндэтгэл  
Тайланг  
2025.12.18  
9131701  
ТУС6846

танилцуулах тохиолдолд эл хэлэлцээрийн холбогдох заалтыг зөрчих эсэх, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн болон албаны нууц задруулсан гэж үзэх эсэх талаар дүгнэлт гаргаж, холбогдох зөвлөмжийг ирүүлэхийг хүсье.

Хэлэлцээрийн монгол хэл дээрх хувь, ЭСЯ-наас ирүүлсэн ноот бичгийн хуулбар хувийг тус тус хавсаргав.

Хавсралт: 10 хуудастай.

Хувийг: ЗГХЭГ-т



Гадаад харилцааны яам  
Удирдлага  
Төрийн нарийн бичгийн дарга  
Лханаажав МӨНХТҮШИГ  
2025-12-19 09:51:45

ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР  
Бүртгэлийн дугаар ...08...  
**ХУУЛБАР ХУВЬ**  
..... *Ахуй Ахуй Ашиг* .....  
( Албан тушаалын нэр )  
..... *М.С.М.* .....  
(гарын үсэг)(гарын үсгийн нэр)  
20 *26* оны *05* сар сар *06*

Төрийн нарийн бичгийн дарга  
М.С.М.  
Удирдлага  
М.С.М.  
Гадаад харилцааны яам  
М.С.М.  
9131701  
TUCOR46



**ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД БООМТЫН ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР ЗАМ,  
НҮҮРСНИЙ ХУДАЛДАА, ТАВАНТОЛГОЙН НҮҮРСНИЙ УУРХАЙН ХҮЧИН  
ЧАДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

"Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоох тухай Хамтарсан тунхаглал"-д үндэслэж,

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар (цаашид хамтад нь "Талууд", тусад нь "хятадын тал", "монголын тал" гэх) нь,

Хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдлөг болгож,

Харилцан ашигтай, эрх тэгш, аж ахуйн нэгжийн манлайллыг дэмжсэн, зах зээлийн үйл ажиллагаа болон олон улсын туршлагад нийцсэн зарчмыг тус тус баримталж,

"Гурвыг цогцоор" зарчимд тулгуурлаж "Гашуунсухайт-Ганцмод" боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалт, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааг хэрэгжүүлэхээр хэлэлцэн тохиролцов

**I. НЭР ТОМЬЁО**

- (I) Энэхүү хэлэлцээрт дурдсан дараах нэр томьёог доор дурдсанаар ойлгоно.

"Гурвыг цогцоор" гэж Талуудад тогтвортой, урт хугацааны эдийн засгийн үр өгөөжтэй байх нөхцөлийг бүрдүүлэх "Гашуунсухайт-Ганцмод" боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэлнэ. Хоёр улсын аж ахуйн нэгж тус бүр зах зээлийн зарчимд үндэслэн нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны харилцан ашигтай гэрээг байгуулна. Эдгээр гэрээ нь ашигт малтмалын тогтвортой нийлүүлэлтийг хангах зорилгоор Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэхтэй холбоотой цогц арга хэмжээг агуулна

(II) Энэхүү хэлэлцээрт тусгагдаагүй аливаа нэр томъёог Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу тайлбарлана. Ойлголтын зөрүүтэй заалтыг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

## II. ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАРИУЦАХ БАЙГУУЛЛАГА

(I) Талууд энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилтийг хариуцах дараах байгууллагыг тодорхойлов. Үүнд

Монголын талаас: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам  
Хятадын талаас: Үндэсний хөгжил, шинэчлэлийн хороо

(II) Төслийн хэрэгжилттэй холбоотой түүхэн нөхцөл байдлыг харгалзан төслийг цаашид саадгүй хэрэгжүүлэх зорилгоор Талуудын холбогдох аж ахуйн нэгжүүд энэхүү Хэлэлцээрийн хүрээнд үйл ажиллагаагаа эрчимжүүлнэ. Холбогдох аж ахуйн нэгжүүдэд доор дурдсан аж ахуйн нэгжийг хэлэх бөгөөд түүгээр хязгаарлахгүй.

Монголын талаас: "Эрдэнэс Тавантолгой" ХК (төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж) болон түүний хамаарал бүхий хуулийн этгээдүүд байна.

Хятадын талаас: "Чайна Энержи хөрөнгө оруулалтын корпорац" (төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж) болон түүний хамаарал бүхий хуулийн этгээдүүд, эсхүл "Чайна Энержи хөрөнгө оруулалтын корпорац", түүний хамаарал бүхий хуулийн этгээдтэй хамтран ажилладаг хятадын санхүүжилттэй байгууллага, аж ахуйн нэгж байна.

## III. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ХҮРЭЭ

Талууд "Гурвыг цогцоор" хамтын ажиллагааны зарчмыг хэрэгжүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэхийн тулд дараах гурван цогц арга хэмжээг дэмжинэ. Үүнд:

### (I) Хил дамнасан төмөр замыг хамтран барих

1. Талууд "барилгын ажлын нарийвчилсан төлөвлөгөө, стандарт зэрэг холболтын ажлыг хамтран гүйцэтгэх, өөр өөрийн нутаг дэвсгэр дэх төмөр замын санхүүжилтийг талууд өөрсдөө хариуцах, төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг зэрэг дуусгах" зарчмыг баримтална. Талууд 2024 оны 4 дүгээр сард байгуулсан "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын гүүрэн байгууламжийг хамтран барих тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн дагуу тус тусын нутаг дэвсгэр дээрх төмөр зам, боомтын бүтээн байгуулалт болон хөрөнгө оруулалтын асуудлыг өөрсдөө хариуцна. Талууд тус тусын төмөр замын барилгын

МОНГОЛ  
УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР  
БҮГД  
НАЙРАМДАХ  
ХАТАД АРД  
УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР  
ХООРОНДЫН  
ХЭЛЭЛЦЭЭР

стандарт болон дүрэм, журмыг дагаж мөрдөнө. Аж ахуйн нэгж хооронд бүтээн байгуулалтын ажлын гэрээнд гарын үсэг зурах, төслийг эхлүүлэх хугацааны талаар харилцаа холбоог хадгалахад дэмжлэг үзүүлж, бүтээн байгуулалтын ажлыг аль болох эрт эхлүүлэхийг эрмэлзэнэ. Аж ахуйн нэгж хооронд нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээ болон Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэхтэй холбоотой хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурах нь хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх урьдач нөхцөл болно.

2. Талууд өөр өөрийн нутаг дэвсгэрт төмөр замын бүтээн байгуулалтын чанарт тавих хяналтыг хариуцах бөгөөд хил холболтын хэсгийн чанарын хяналтыг хамтдаа хариуцна.

3. Талууд энэхүү төмөр замыг хил дамнасан нүүрс тээвэрлэлтэд түлхүү ашиглахыг дэмжиж, хоёр улсын аж ахуйн нэгжүүд хооронд худалдсан нүүрсийг уг төмөр замаар тэргүүн ээлжид тээвэрлэнэ.

### (II) Нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээ

Талууд "Гашуунсухайт-Ганцмод" төмөр зам болон хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалт удааширсан, Талуудад учирсан цаг хугацаа болон эдийн засгийн алдагдал, хоёр талын хооронд өмнө нь байгуулж байсан нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээний жишиг зэргийг харгалзан үзэж, харилцан зөвшилцөх замаар хоёр улсын аж ахуйн нэгжүүд "Эрдэнэс Тавантолгой" ХК болон Хятадын төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн хооронд байгуулсан нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээний хамгийн сүүлд баталгаажсан үнэ (энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурах өдрөөс өмнөх) анхны үнэ болгох (FCA-нүүрс нийлүүлэх цэг нь Тавантолгойн уурхайн талбай)-оор тохиролцсон бөгөөд дараагийн үнийг талуудын харилцан зөвшилцсөн механизм буюу "анхны үнэ + хамтран сонгож авсан улирлын индексийн тохируулга"-аас гаргана. Нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээнд нүүрсний чанар, хэмжээ, хугацааг тохирч хэлэлцээрт тохирсон үнийн аргачлалыг баримтална.

### (III) Нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх

1. Хил дамнасан төмөр замын тээврийн хэмжээ, эдийн засаг, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг урт хугацаанд хангах, төмөр замаар тээвэрлэх ачаа тээврийн хэмжээг баталгаажуулах зорилгоор Монголын тал "Эрдэнэс Тавантолгой" ХК Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадал, нүүрс олборлолтын хэмжээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Талууд шинээр уурхайн талбайг хөгжүүлэх, олборлолтын үйл ажиллагааг эхлүүлэх зорилгоор Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх бүтээн байгуулалтын хамтын ажиллагаанд энэхүү гэрээний II зүйлийн (II) дахь хэсэгт заасан аж ахуйн нэгжүүдийг арилжааны зарчмаар оролцохыг дэмжиж, хамтран ажиллана.

Эрдэнэс Тавантолгой ХК  
Төрийн өмчийн хэргийн  
Төрийн өмчийн хэргийн  
Төрийн өмчийн хэргийн  
Төрийн өмчийн хэргийн

2 Эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хүрээнд хайгуул төлөвлөлт олборлолтын явцад орчин үеийн техник технологийг нэвтрүүлж байгаль орчинд ээлтэй, бүтээмж өндөртэй үйл ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөлийг хангана

#### IV. ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ

(I) Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлснээр "Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоох тухай Хамтарсан тунхаглал"-ын хүрээнд "Гашуунсүхайд- Ганцмод" боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ

(II) Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх хугацаанд, хоёр улсын аж ахуйн нэгж хооронд хэлэлцээрийн үр дүнг хамтын ажиллагааны чиглэл бүрээр дүгнэж, цаашид хамтран хэрэгжүүлэх арга хэмжээг цаг хугацаанд нь төлөвлөнө.

(III) Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх хугацаанд, хоёр улсын аж ахуйн нэгж хооронд уг хэлэлцээрийн хүрээнд нүүрс худалдах, худалдах авах урт хугацааны гэрээ шинээр байгуулах нь хоёр улсын аж ахуйн нэгж хооронд өмнө нь байгуулсан нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээний биелэлтэд нөлөөлөхгүй

#### V. БУСАД


Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш Талууд хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын бусад төсөл болон эрчим хүчний нүүрсний экспортыг идэвхтэй урагшлуулна. Талууд хот байгуулалт, орон сууцжуулалт болон дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана. Талууд боомтуудын хамтын ажиллагааг бэхжүүлж, гаалийн нэвтрүүлэх чадавхыг нэмэгдүүлнэ. Талууд аж ахуйн нэгжүүдийг арилжааны зарчмаар сэргээгдэх эрчим хүчтэй холбоотой хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд үргэлжлүүлэн дэмжинэ

#### VI. НЭМЭЛТ ЗААЛТ

Талууд өөрсдийн дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангаснаар энэхүү Хэлэлцээр нь хүчин төгөлдөр болох бөгөөд 16 жилийн хугацаанд хүчинтэй байна. Аль нэг тал энэхүү хэлэлцээрийг цуцлах тохиолдолд дипломат шугамаар нөгөө талдаа энэ талаар бичгээр мэдэгдэж, нөгөө талын зөвшөөрлийг авна. Хэлэлцээрийг цуцлах гэж буй тал нөгөө талын зөвшөөрлийг авснаас хойш зургаан сарын дараа хэлэлцээр цуцлагдана. Хэлэлцээрийг цуцалснаар уг хэлэлцээрийг







## 中华人民共和国大使馆

376/2025

蒙古国外交部：

中华人民共和国驻蒙古国大使馆向蒙古国外交部致意并谨通报如下：

中方注意到蒙古媒体报道蒙方出台关于公开国家涉密信息的政府决议，并称将公布包括《中华人民共和国政府和蒙古政府关于开展甘其毛都—嘎舒苏海图跨境铁路、煤炭贸易、TT矿扩能合作的协议》在内的相关文件。

中方谨提及蒙古外交部2025年2月11日A/25-227号确认上述协议最终文本的照会以及2025年4月30日A/25-602号确认上述协议生效的照会，并提请蒙方关注协议第六款第五条相关表述：“双方同意，在未得到协议另一方书面认可的前提下，在本协议商签、审议及后续实施过程中，协议一方向另一方提供的信息仅供内部使用，双方均不得向任何第三方透露本协议及合作过程中相关信息。上述第三方包括但不限于双方没有参与本协议框架下铁路建设、煤炭贸易及煤矿开发合作的政府部门或企业。协议的修改及其他条款的失效不影响本条款的效力及履行。”



中方据此郑重提醒蒙方重视上述协议条款规范事项并予以落实。

顺致崇高敬意。



中华人民共和国驻蒙古国大使馆

2025年10月9日于乌兰巴托

(Translation)

376 /2025

The Embassy of the People's Republic of China in Mongolia presents its compliments to the Ministry of Foreign Affairs of Mongolia and has the honor to state as follows.

The Chinese side noticed that Mongolian media reported the Government Order of Publicizing National Confidential Information and claimed to release files including the *Agreement Between the Government of the People's Republic of China and the Government of Mongolia on the Gants Mid-Gashuun Sukhait Border Railway, Coal Trade and TT Coal Mine Capacity Expansion Cooperation.*

With reference to the note A/23-227 on February 11, 2025, that confirms the final version of the above-mentioned agreement and the note A/25-602 on April 30, 2025, that confirms the effectiveness of the agreement, the Chinese side requests the Mongolian side to pay attention to Clause V of Article VI: *The two sides agree that the information provided by one side to the other during the process of negotiation, review and implementation is for internal use only and shall not be disclosed to any third party without written consent from the other side beforehand. The above mentioned third party includes but is not limited to government departments or companies that are not involved in the railway construction, coal trade, and coal mine development cooperation under the framework of this agreement. The amendment, termination, or expiration of other terms of the agreement will not affect the validity and enforcement of this term*

The Chinese side therefore solemnly reminds the Mongolian side to pay close attention to the clause mentioned above and implement the clause accordingly.




The Embassy of the People's Republic of China in Mongolia avails itself of this opportunity to renew to the Ministry of Foreign Affairs of Mongolia the assurance of its highest consideration.

(Seal)

Ulaanbaatar, October 9, 2025

Embassy of the People's Republic of China in Mongolia,  
ULAANBAATAR



Албан бус орчуулга

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЭЛЧИН САЙДЫН ЯАМ

376/2025

Монгол Улсын Гадаад харилцааны яаманд:

Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамнаас Монгол Улсын Гадаад харилцааны яаманд дараахыг мэдэгдэх завшаан тохиолдов.

Монголын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр Монгол Улсын Засгийн газраас нууцад хамаарах мэдээллийг нийтэд ил болгох шийдвэрийг гаргасан тухай нийтэлжээ. Энэхүү мэдээлэлд "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-тэй холбоотой мэдээлэл багтсан явдалд хятадын тал онцгой анхаарч байна.

Монгол Улсын Гадаад харилцааны яамнаас дээрх хэлэлцээрийн хэлэлцсэн тохиролцсон эцсийн төслийг 2025 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн А/25-227 дугаартай ноот бичиг, хэлэлцээр хүчин төгөлдөр болсон тухай 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн А/25-602 дугаартай ноот бичгээр тус тус хятадын талд мэдэгдсэн. Хятадын талаас тус хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн 5-т "Хэлэлцээрийн хэлэлцээ, үнэлгээ болон хэрэгжилтийн явцад нэг талаас нөгөө талдаа дамжуулсан мэдээллийг Талууд зөвхөн дотоод хэрэгцээндээ ашиглах бөгөөд нөгөө талаасаа бичгээр урьдчилан зөвшөөрөл авахгүйгээр аливаа нэг гуравдагч этгээдэд задруулахыг хориглоно. Энэхүү гуравдагч этгээд гэдэгт уг хэлэлцээрийн хүрээнд төмөр замын бүтээн байгуулалт, нүүрсний худалдаа, нүүрсний уурхайн бүтээн байгуулалтын хамтын ажиллагаанд оролцоогүй төрийн байгууллага, аж ахуйн нэгжийг ойлгох бөгөөд тэдгээрээр хязгаарлахгүй. Хэлэлцээрийн бусад заалтад нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах эсхүл дуусгавар болгох нь уг нөхцөлийн үйлчлэлд үл нөлөөлнө" гэж заасныг монголын тал анхааралдаа авахыг хүсэж байна.

Иймд хятадын талаас дээрх заалтыг монголын талд эргэн сануулж, цаашид анхааралдаа авч, хэрэгжүүлэхийг хүсэв.

Гүнээ хүндэтгэсэн

Handwritten notes in Mongolian script:

1. Хятадын талд мэдэгдсэн  
2. Хятадын талд мэдэгдсэн  
3. Хятадын талд мэдэгдсэн  
4. Хятадын талд мэдэгдсэн  
5. Хятадын талд мэдэгдсэн  
6. Хятадын талд мэдэгдсэн

913170  
140884

ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР  
Бүртгэлийн дугаар 08  
БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЭЛЧИН САЙДЫН ЯАМ  
..... АХХХ ..... 2025 оны 10 дугаар сарын 9-ний өдөр  
(Албан тушаалтан нэр)  
.....  
(гар ..... айлал)  
26 05 06

2025 оны 10 дугаар сарын 9-ний өдөр  
Улаанбаатар хот




МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

Жуулчны гудамж-3, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, 15160, Утас: 9226 3656,  
9226 3017, Факс: (976) 9226 3656,  
Цахим шуудан: info@gia.gov.mn,  
Цахим хуудас: www.gia.gov.mn

2026.01.08 № ТЭГ 01/09  
танай 2025.12.18 -ны № 02/6013 -Т

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Л.МӨНХТҮШИГ ТАНАА



**Хариу хүргүүлэх тухай**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай" хэлэлцээр нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг болон Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт"-д хамаарахгүй болно.

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд нууц мэдээллийг харилцан хамгаалах, гэрээ, хэлэлцээр байгуулаагүй болно.

Түүнчлэн Олон улсын гэрээний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэгт "Монгол Улсын олон улсын гэрээний үүргийн биелэлтэд гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах талаар зөвлөмж, чиглэл өгч, шаардлагатай бол энэ тухай санал боловсруулж Улсын Их Хурал, эсхүл Засгийн газарт танилцуулна." гэж заажээ.

Иймд "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай" хэлэлцээр, түүний бэлтгэл ажил, аж ахуйн нэгж хоорондын хамтын ажиллагааны гэрээ, баримт бичиг, үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах, нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд олон нийтийг мэдээллээр хангаж, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хуралд танилцуулах асуудалд тагнуулын байгууллагаас зөвлөмж хүргүүлэх боломжгүй болохыг үүгээр уламжилъя.



П.ОДОНБААТАР



**МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД**

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251  
Утас: (976-51) 26 31 79, Факс: (976-11) 31 23 15,  
Цахим шуудан: info@mrt.gov.mn,  
Цахим хуудас: www.mrt.gov.mn

2026.05.01 № 01/2094  
танай 2026.04.24 -ны № ХЭГ/1346 -т

Хариу хүргүүлэх тухай

Танаас 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн ХЭГ/1346 тоот албан бичигтэй танилцаж дараах хариуг хүргүүлж байна.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд байгуулсан "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгой нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай хэлэлцээр"-ийн хүрээнд тус яам болон харъяа байгууллагын зүгээс холбогдох байгууллагатай байгуулсан дараах хэлэлцээр, гэрээг хавсралтаар хүргүүлж байна. Үүнд:

1. "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын гүүрийг хамтран барих тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр байгуулсан.

2. "Тавантолгой төмөр зам" ХХК болон БНХАУ-ын "Чайна энерги ганцмод төмөр замын хөрөнгө оруулалт" ХХК хоорондын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам барих тухай хэлэлцээр"-ийг 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан.

3. "Тавантолгой төмөр зам" ХХК болон "Хятадын төмөр замын барилгын гүүрийн инженер товчоо групп" ХХК хооронд байгуулсан "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэх гэрээ"-г 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан.

Дээрх хэлэлцээр болон гэрээ нь төрийн болон албаны нууцад хамаараагүй болно.

Хавсралт 102 хуудастай.



Зам, тээврийн яам  
Сайд  
Б.Дэлгэрсайхан  
2026.05.01 11:10



**ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД БООМТЫН  
ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР ЗАМЫН ГҮҮРИЙГ ХАМТРАН БАРИХ ТУХАЙ  
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,  
БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР  
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар (цаашид хамтад нь "Талууд", тусад нь Тал" гэх) хоёр орны төмөр замын холболтыг гүнзгийрүүлэх, Монгол, Хятадын төмөр замын тээврийн чанарыг өндөр түвшинд хөгжүүлэхийг урагшлуулж, "Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын гэрээ"-ний дагуу Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын гүүрийг хамтран барих асуудлаар дараах зүйлийг харилцан тохиролцов.

**1 дүгээр зүйл. Нэр томьёо**

Энэхүү хэлэлцээрт хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

1.1 "Хил дамнасан төмөр замын гүүр" гэж Монголын талын "Гашуунсухайт" төмөр замын өртөө болон Хятадын талын "Ганцмод" төмөр замын өртөөг өргөн болон стандарт царигаар холбосон, улсын хилийн шугам даиран гарч буй төмөр замын гүүрийг хэлнэ.

1.2 "Бүтээн байгуулалтын хаалттай бүс" гэж Талуудын өөрсдийн нутаг дэвсгэрт хил дамнасан төмөр замын гүүр барих зориулалттай тусгаарлагдсан, хаалттай талбайг хэлнэ.

1.3 "Ажилтан" гэж бүтээн байгуулалтын хаалттай бүсэд хил дамнасан төмөр замын гүүр барих ажилд оролцож буй хүнийг хэлнэ.

## 2 дугаар зүйл. Хариуцах болон гүйцэтгэх байгууллага

2.1 Энэхүү хэлэлцээрийн хэрэгжлтийг удирдан зохион байгуулах үүрэг бүхий байгууллага нь Монголын талаас Зам, тээврийн хөгжлийн яам, Хятадын талаас Улсын төмөр замын газар байна.

2.2 Хил дамнасан төмөр замын гүүрийн бүтээн байгуулалтыг гүйцэтгэх байгууллага нь Монголын талаас "Тавантолгой төмөр зам" ХХК, Хятадын талаас "Чайна Энержи хөрөнгө оруулалтын групп" ХХК байна.

2.3 Аль нэг талын хариуцах болон гүйцэтгэх байгууллагад өөрчлөлт өрсөн тохиолдолд нөгөө талдаа дипломат шугамаар бичгээр мэдэгдэнэ.

## 3 дугаар зүйл. Хил дамнасан төмөр замын гүүрийн байршил

Хил дамнасан төмөр замын гүүр нь Монгол Улсын Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь Гашуунсухайт төмөр замын өртөө болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах орны Баяннуур хотын Улаатын дунд хошууны нутаг дахь Ганцмод төмөр замын өртөө хооронд байрлана. Төмөр замын улсын хил дайран гарах цэг нь Монгол, Хятадын хилийн 703 дугаар тэмдгээс зүүн тийш 2495.6 метр орчим хэсэг (солбицол  $X=713831.33$ ,  $Y=4698761.14$ )-т байна. Барилга угсралтын ажлын явцад хилийн шугамын дагуу баруун тийш 10 метр зүүн тийш 40 метрийн зайд тохируулга хийх боломжтой. Талууд судалгаа, зураг төсөлд ижил хавтгай солбицлын системийг (WGS84, UTM48N координатын системийн талбай N48) ашиглах бол Монголын тал Балтийн тэнгисийн өндрийн систем (Балтийн тэнгисийн өндөр + 0.453 м=1985 үндэсний өндрийн өгөгдөл), Хятадын тал 1985 үндэсний өндрийн системийг ашиглана.

## 4 дүгээр зүйл. Хамтын ажиллагааны зарчим

Хил дамнасан төмөр замын гүүр барих ажлыг зохион байгуулах, дэмжих зорилгоор Талууд хамтын ажиллагааны дараах зарчмыг тодорхой болгов. Үүнд

4.1 Хил дамнасан төмөр замын гүүр барих хариуцлагын хязгаарыг гүүрийн төмөр замын холболтын цэг (өргөн болон стандарт царигийг оролцуулан)-ээр тогтооно. Төмөр замын холболтын цэг нь Талуудын улсын хилийн шугам дээр байх бөгөөд газар зүйн солбицлыг 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн Монгол, Хятад хоёр улсын ноот бичиг (Монгол Улсын Гадаад харилцааны яамны А/21-1089 дугаартай ноот бичиг, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гадаад хэргийн яам [2021] №54 дугаартай ноот бичиг)-ийн дагуу тогтооно.

4.2 Хил дамнасан төмөр замын гүүрийг барихдаа хариуцлагатай чиглэлийг өөрчлөхгүй, тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчинг сүйтгэхгүй. Хил дамнасан төмөр замын гүүрийг барих ажил нь Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын гэрээ-нд нийцсэн байна.

4.3 Талуудын хил дамнасан төмөр замын гүүрийн бүтээн байгуулалтыг гүйцэтгэх байгууллагууд өөрсдийн хариуцлагын хязгаарын доторх судалгаа, зураг төсөл, барилга угсралт болон бусад бүтээн байгуулалттай холбоотой зардлыг хариуцна.

4.4 Судалгаа, зураг төслийн ажлыг Талуудын гүйцэтгэх байгууллагуудын хамтран итгэмжлэгдсэн төмөр замын зураг төслийн байгууллага гүйцэтгэнэ. Ингэхдээ өргөн царигаар Монголын стандартыг, стандарт царигаар Хятадын стандартыг тус тус ашиглана.

4.5 Талуудын гүйцэтгэх байгууллагууд хил дамнасан төмөр замын гүүрийн өөрсдийн талын бүтээн байгуулалтыг хариуцаж, барилгын ажлыг нэгэн зэрэг гүйцэтгэнэ.

4.6 Талуудын гүйцэтгэх байгууллагууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гүүрийн тулгуур болон хил дамнасан бусад объектын барилга угсралтын ажлыг нэг тал нь гүйцэтгэж, нөгөө тал нь хэлэлцэн тохирсон хувь хэмжээгээр зардлыг хариуцна.

4.7 Талууд бүтээн байгуулалтыг эхлүүлэх хугацааг хэлэлцэн тохиролцож, хамтран эхлүүлнэ. Угсралт олон бусад бүтээн байгуулалттай холбоотой зардлыг

4.8 Хил дамнасан төмөр замын гүүрийг барих хугацаанд бүтээн байгуулалтын хаалттай бүсийн эргэн тойрны аюулгүй байдлыг тухайн орон нутгийн захиргаа болон гүйцэтгэх байгууллагууд хариуцна.

## 5 дугаар зүйл. Бүтээн байгуулалтын хаалттай бүсийн хил хязгаар болон зохион байгуулалт

5.1 Шаардлагатай гэж үзвэл Талууд өөрийн нутаг дэвсгэр дээр байгуулах бүтээн байгуулалтын хаалттай бүсийн хэмжээг тодорхойлж болно. Бүтээн байгуулалтын хаалттай бүсийн хилийн зааг зохион байгуулах ажлыг Талуудын орон нутгийн захиргаа хил хамгаалах гаань, шилжилт хөдөлгөөн болон бусад байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр тогтооно.

5.2 Талууд өөрийн талын бүтээн байгуулалтын хаалттай бүсэд зөвхөн хил дамнасан төмөр замын гүүрийн бүтээн байгуулалтад оролцож буй ажилчид, техник

тоног төхөөрөмж, бараа, тээврийн хэрэгсэл түүнд барилгын материал, зүйл хэрэгсэлд шаардлагатай материалуудыг оруулж гаргана. Тус бүсэд эрх гэрээ асуудлыг уг хэлэлцээрийн 6 дугаар зүйлд зөвснө дагуу зохицуулна.

5.3 Талууд өөрсдийн бүтээн байгуулалтын хаалттай бүсэд холбогдох байгууллагуудын хамтарсан хяналт, шалгалтыг явуулахгүй. Нэг талын ажилчид, техник хэрэгсэл, бараа, тээврийн хэрэгслийг нөгөө талын бүтээн байгуулалтын хаалттай бүс рүү оруулж, гаргахаас өмнө холбогдох байгууллагаас зөвшөөрөл авсны дараа чөлөөтэй нэвтрүүлэх бөгөөд бүтээн байгуулалтын хаалттай бүсээс гадагш гарахыг хориглоно. Хэрэв шаардлагатай гэж үзвэл нөгөө талын зөвшөөрлийг авч, дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасны үндсэн дээр гарч болно.

5.4 Бүтээн байгуулалтын хаалттай бүсийн эргэн тойронд холбогдох таних тэмдгийг байршуулна. Бүтээн байгуулалтын хаалттай бүсэд байгаа ажилчид, техник, тоног төхөөрөмж, бараа, тээврийн хэрэгсэл нь Талуудын хил хамгаалах, гааль, шилжилт хөдөлгөөний байгууллагатай тохиролцсон таних тэмдэгтэй байна.

5.5 Хил дамнасан төмөр замын гүүрийг барих хугацаанд Талуудын өрсөн нутгийн захиргааны байгууллага болон гүйцэтгэх байгууллагууд бүтээн байгуулалтын хаалттай бүсэд байрлах ажилчид, техник, тоног төхөөрөмж, бараа, тээврийн хэрэгсэл болон бусад эд хөрөнгийн аюулгүй байдлыг хангана. Тус бүсэд хуулиар хориглосон барааг нэвтрүүлэхийг хориглоно. Бүтээн байгуулалтын хаалттай бүсэд ажиллаж байгаа ажилтнууд нөгөө талын бүтээн байгуулалтын хаалттай бүсэд нэвтрэх, оршин суухдаа тухайн улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө. Бүтээн байгуулалтын хаалттай бүсэд хууль бус, тэмт хэргийн шинжтэй үйлдэл гарсан тохиолдолд тухайн улсын хууль сахиулах эрх бүхий байгууллага шийдвэрлэнэ.

**6 дугаар зүйл. Ажилчид, техник, тоног төхөөрөмж, бараа, тээврийн хэрэгслийг нөгөө талын бүтээн байгуулалтын хаалттай бүсэд оруулах, гаргах асуудал**

6.1 Талуудын холбогдох байгууллагууд ажилчид, техник, тоног төхөөрөмж, бараа, тээврийн хэрэгслийг бүтээн байгуулалтын хаалттай бүсээр нэвтрүүлэх, түүнчлэн бүтээн байгуулалтын хаалттай бүс дотор хил дамнасан хөдөлгөөнийг хялбарчлах шаардлага гарвал түр гарц нээх асуудлыг Талуудын холбогдох журмын дагуу зохицуулна.

6.2 Хил дамнасан төмөр замын гүүрийн бүтээн байгуулалт эхлэхээс өмнө шаардлагатай гэж үзвэл Талуудын хил хамгаалах, гааль, шилжилт хөдөлгөөний байгууллага бүтээн байгуулалтын хаалттай бүсэд ажилчид оруулж, гаргахтай

холбоотой асуудлаар тусгайлан зөвлөлдөж болно

6.3 "Монгол Хятадын хилийн боомт тэдгээрийн дэлгэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр", "Иргэд харилцан зөрчих журмын тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т заасан хүчин төгөлдөр баримт бичгийн хамт бүтээн байгуулалтын хаалттай бүсээр нэвтэрнэ

Бүтээн байгуулалтын хаалттай бүсэд орох, гарах шаардлагатай ажилчдын жагсаалт (ажилчдын тоо, ажлын хэсгийн ахлагчийн нэр, хувийн мэдээлэл, нэвтрэх, гарах бичиг баримт зэрэг холбогдох мэдээлэл, нөгөө талын барилгын хаалттай бүсэд орохоор төлөвлөж буй хүмүүсийн жагсаалт зэрэг), түүнчлэн хил дамнасан төмөр замын гүүр барихад шаардлагатай техник, тоног төхөөрөмж, бараа, тээврийн хэрэгслийн жагсаалтыг Талуудын холбогдох байгууллага урьдчилан солилцоно

#### 7 дугаар зүйл. Гаалийн хяналт, бүрдүүлэлт

Хил дамнасан төмөр замын гүүрийг барихад шаардлагатай техник, тоног төхөөрөмж, бараа, тээврийн хэрэгслийг хилээр оруулж гаргахтай холбоотой гаалийн хяналт, бүрдүүлэлтийн асуудлыг Талуудын хооронд байгуулсан хоёр талт гэрээ, нэгдэн орсон олон талт гэрээ болон хоёр улсын дотоодын хууль журмын дагуу шийдвэрлэнэ

#### 8 дугаар зүйл. Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах

Талууд хэлэлцээрийг байгуулсны дараа нэмэлт, өөрчлөлт оруулах бол тусад нь нэмэлт протокол байгуулж болно. Энэхүү протокол нь хэлэлцээрийн залшгүй хэсэг болох бөгөөд энэхүү гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр болно

#### 9 дүгээр зүйл. Бусад асуудлаар хэлэлцээ хийх

Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсны дараа Талуудын холбогдох байгууллага энэхүү хэлэлцээрт заасны дагуу хил дамнасан гүүр барихтай холбоотой гадархай асуудлаар хэлэлцээ хийж шаардлагатай гэж үзвэл холбогдох баримт бичгийг бүрдүүлж болно

10 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэх

Хил дамнасан төмөр замын гүүрийг барих явцад үүссэн мэдээллийг талуудын хэлбэлгэдэх байгууллага эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэнэ

11 дүгээр зүйл. Хэлэлцээр хүчин төгөлдөр болох,  
хэлэлцээрийн хүчинтэй хугацаа

Энэхүү хэлэлцээр нь 5 жилийн хугацаанд хүчинтэй. Талууд энэхүү хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгох дотоодын хуулийн шаардлага хангасан тухайгаа дипломат шугамаар бичгээр харилцан мэдэгдэнэ. Энэхүү хэлэлцээр нь харилцан мэдэгдсэн сүүлчийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Энэхүү гэрээний хугацаа хил дамнасан төмөр замын гүүрийг барьж ашиглалтад оруулснаас хойш 60 хоногийн дараа дуусгавар болно.

Энэхүү гэрээнд гарын үсэг зурах этгээд нь тус тусын Засгийн газраас гарын үсэг зурах эрх авсан итгэмжлэгдсэн этгээд байна.

Энэхүү хэлэлцээрийг 2024 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр Улаанбаатар хотноо монгол, хятад хэлээр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

Монгол Улсын  
Засгийн газрыг төлөөлж

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын  
Засгийн газрыг төлөөлж



Монгол Улсын Зам, тээврийн  
хөгжлийн яамны Төрийн нарийн  
бичгийн дарга С.Батболд

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын  
Улсын төмөр замын газрын дэд  
дарга Ань Лүшөн

МОНГОЛ УЛСЫН "ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ" ХХК

болон

БНХАУ-ЫН "ЧАЙНА ЭНЕРЖИ ГАНЦМОД ТӨМӨР ЗАМЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ" ХХК

хоорондын

ГАСУУНСУХАЙТ-ГАНЦМОД БООМТЫН ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР ЗАМ БАРИХ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР

Нэг талаас  
"ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ" ХХК

Нөгөө талаас,  
"ЧАЙНА ЭНЕРЖИ ГАНЦМОД ТӨМӨР ЗАМЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ" ХХК

2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр

Handwritten signature

## 1 дүгээр зүйл. Нэр томьёо

Гэрээний нэр томьёог дараах байдлаар ойлгоно:

- 1.1 Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнансан төмөр замыг цаашид "Хил дамнансан төмөр зам", Монгол Улсын "Тавантолгой төмөр зам" ХХК-ийг цаашид "Тавантолгой төмөр зам компани", "Чайна Энержи Ганцмод төмөр замын хөрөнгө оруулалт" ХХК-ийг цаашид "Ганцмод төмөр зам компани" гэж тус тус товчилно.
- 1.2 Бүтээн байгуулалтын менежментийн компани гэж дараах байгууллагуудыг хэлнэ. Үүнд  
Монголын талын бүтээн байгуулалтын менежментийн компани нь Монгол Улсын Тавантолгой төмөр зам компани байна.  
Хятадын талын бүтээн байгуулалтын менежментийн компани нь БНХАУ-ын Ганцмод төмөр зам компани байна.
- 1.2. Зураг төслийн байгууллага гэж хил дамнансан төмөр замын зураг төслийг боловсруулсан байгууллагыг хэлэх бөгөөд Монгол, Хятад хоёр талын зураг төслийн байгууллага нь "Хятадын төмөр замын зураг төслийн корпораци" ХХК байна.
- 2.1. Гашуунсухайт-Ганцмод хил дамнансан төмөр замын улсын хилийн шугам дайран өнгөрөх цэгийг Монгол Улсын Гадаад харилцааны яам, БНХАУ-ын Гадаад харилцааны яамдууд 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр харилцан ноот бичиг солилцон тогтоосныг.
- 2.2. 2022 оны 8 дугаар сарын 8-ны өдөр үзэглэсэн "Монгол Улсын Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам болон БНХАУ-ын Үндэсний хөгжил, шинэчлэлийн хороо хоорондын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнансан төмөр замын холболтын тухай харилцан ойлголцлын санамж бичиг"-ийг.

2.3. "Тавантолгой төмөр зам" ХХК болон Чайна Энержи Группийн "Интернэшил девелопмент" ХХК, "Чайна Энержи Баошөн төмөр зам групп" ХХК хооронд 2023 оны 2 дугаар сарын 11-ний өдөр байгуулсан "Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод хилийн боомтыг холбох төмөр замын бүтээн байгуулалтыг дэмжих тухай Санамж бичиг"-ийг.

2.4. 2024 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр үзэглэсэн "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнансан төмөр замын гүүрийг хамтран барих тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг.

2.5. Монгол, Хятад талуудын 2025 оны 2 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнансан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг тус тус үндэслэн байгуулав.

## 3 дугаар зүйл. Хэлэлцээрийн зорилго

3.1. Энэхүү хэлэлцээрийн зорилго нь хил дамнансан төмөр замыг холбогдох стандарт болон батлагдсан зураг төслийн дагуу чанарын өндөр түвшинд, өндөр стандартыг баримтлан, аюулгүй байдлыг хангаж, үр бүтээмжтэйгээр зэрэгцээ барьж байгуулан, нэгэн зэрэг ашиглалтад оруулахад оршино.

3.2. Монгол, Хятад хоёр улс тус тусын нутаг дэвсгэр дэх төмөр замын суурь бүтэцэд хөрөнгө оруулах, барих, ашиглалтад оруулах, хүлээн авах, ашиглах, турших ажлыг харуулна.

## 4 дүгээр зүйл. Бүтээн байгуулалтын зарчим

Хил дамнансан төмөр замын бүтээн байгуулалтыг харилцан уялдаатай нэгдсэн зохицуулалттай хийж гүйцэтгэх зорилгоор талууд хамтын ажиллагааны зарчмыг дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

2

11

26

11

4.1. Хил дамнасан төмөр замыг барихад Монгол, Хятад талууд "Нэгдсэн зураг төсөл, тус тусын бүтээн байгуулалт, нэг удаа холбох" зарчмыг баримтална.

**Тайлбар:** "нэг удаа холбох" гэдгийг Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг тус тусын нутаг дэвсгэрт гүйцэтгэн, нэгэн зэрэг холбохыг ойлгоно.

4.2. Монгол, Хятад хоёр улсын тус тусын хариуцлагын хүрээ нь улсын хилийн шугамаар хязгаарлагдах бөгөөд координатыг 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн Монгол, Хятадын хоёр талын ноот бичиг (Монгол Улсын Гадаад харилцааны яам А/21-1089, БНХАУ-ын Гадаад харилцааны яам {2021} №54 дугаартай ноот бичиг)-ийн дагуу тодорхойлно.

4.3. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам нь нэг гүрэн байгууламжаар холбогдоно. Хоёр улсын улсын хил дайран гарах цэг дээр гүүрний нэг тулгуур байрлах бөгөөд талууд гүүрний тулгуурын төсвийг хамтран тогтоож, тус тусын хил доторх хөрөнгө оруулалтаа хариуцна. Улсын хил дайрах гарах цэг дээрх гүүрний тулгуурыг Хятадын тал барьж, Монголын тал холбогдох зардлыг гаргана. Улсын хил дайран гарах цэг дээрх гүүрний тулгуурыг арчлах, засварлах ажлыг нэг тал нь хариуцаж, нөгөө тал нь холбогдох зардлыг төлнө.

4.4. Төслийн бүтээн байгуулалтын ажил эхлэх хугацааг Монгол, Хятадын Засгийн газрын Гадаад харилцааны ноот бичигт заасан хугацаагаар тооцох бөгөөд Талууд үүнд үндэслэн ажлын төлөвлөгөөг боловсруулан харилцаа холбоогоо бэхжүүлж, нээлтийн ёслолын үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хамтран хангана.

4.5. Хоёр талын бүтээн байгуулалтын менежментийн компани нь хил дамнасан төмөр замын гүүрийг барьж байгуулах явцад ойр орчмын аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлнэ.

4.6. Хил дамнасан төмөр замын гүүрийг барьснаар хилийн шугамын чиглэлийг өөрчилж, тухайн газар нутгийн хүрээлэн буй орчинд хор хохирол учруулж үл болно. Хил дамнасан төмөр замын гүүрийг барих

үйл ажиллагаа нь "Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар болон БНХАУ-ын Засгийн газар хоорондын гэрээ"-ний заалтад нийцсэн байна.

4.7. Хил дамнасан төмөр замын гүүрний бүтээн байгуулалттай холбоотой асуудлыг хоёр улсын Засгийн газар хооронд байгуулсан хэлэлцээрт зааснаар зохицуулна. Талууд өөрсдийн нутаг дэвсгэрийн доторх судалгаа, зураг төсөл, барилга угсралт болон бусад бүтээн байгуулалтын холбоотой зардлыг хариуцна.

4.8. Талуудын бүтээн байгуулалтын менежментийн компаниуд хил дамнасан төмөр замын гүүрний бүтээн байгуулалтыг тус бүрдээ хариуцаж, нэгэн зэрэг гүйцэтгэж, дуусган хүлээлгэн өгнө.

4.9. Хилийн хамгаалалтын бүсийн хашаан доторх барилгын ажлын цар хүрээг төмөр замын шугамын төв тэнхлэгийг төв болгож, баруун, зүүн тийш 50 метрийн зайд тус тус тогтоох бөгөөд хоёр талын бүтээн байгуулалтын менежментийн компани нь өөр өөрийн хилийн хамгаалалт, хилийн шалган нэвтрүүлэх гааль зэрэг байгууллагуудыг хариуцаж барилга угсралтын ажилд дэмжлэг үзүүлнэ.

#### 5 дугаар зүйл. Техникийн стандарт

5.1. Хил дамнасан төмөр замын хил дайрах гарах хэсэг дэх гүүрний хүчилт дээрх төмөр зам нь өргөн, нарийн царигаар зэрэгцэн төлөвлөгдөх бөгөөд нарийн цариг нь баруун талдаа өргөн цариг нь зүүн талдаа байна.

5.2. Талууд хил дамнасан төмөр замын төслийн үндсэн техникийн стандартыг үүгээр тодорхойлов. Төсөлсөн хурд нь 120км/ц; хамгийн бага тахирын радиус энгийн хэсэгт 1200 м, төвөгшилтэй хэсэгт 800 м, баримтлах хэвийн ачаатай талдаа 6%, хоосон талдаа 11%, дотоод шаталтын зүтгүүр, цахилгаанжуулалтын нөхцөл нөөцлөгдсөн, галт тэрэгний жин 10,000 тонн байна.

12/27

12/27

5.3. Талууд төмөр замаар холбогдсоны дараа Монгол Улсаас БНХАУ руу экспортлох төмөр замын тээвэрлэлтийн хүчин чадал жилд 30 сая тонн байх бөгөөд үүнээс хагас вагоноор тээвэрлэх задгай нүүрс жилд 10 сая тонн, чингэлэг тээвэрээр жилд 20 сая тонн тээвэрлэх нөхцөлийг хангасан байхаар тогтов. БНХАУ-аас Монгол Улс руу экспортлох барааны тээвэрлэлтийн хүчин чадал жилд 1 сая тонноос багагүй байх нөхцөлийг хангасан байна.

5.4. Монголын тал задгай нүүрсний тээврийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор одоо ашиглаж буй нүүрс задгайгаар тээвэрлэх вагонууддаа эргэдэг авто угсраа суурилуулан сайжруулалт хийнэ.

5.5. Гашуунсухайт өртөө болон Ганцмод өртөөд нь хоёр улсын өртөөдийн жижүүр ажилчдын хэрэгцээнд зориулж хос шилэн кабель ашиглан хоёр ширхэг зориулалтын оптик дамжуулагч багц төхөөрөмжид шууд холбогдож, өөр өөрсдийн талдаа шууд харилцах боломжтой суурин утас суурилуулсан байна. Талуудын хил нэвтрэх зүтгүүрүүд нь нөгөө улсын өртөөний жижүүртэй радио станцаар холбогдоно. Монголын тал өргөн царигийн зүтгүүрт Хятадын стандартын радио станцыг, Хятадын тал нарийн царигийн зүтгүүрт Монголын стандартын радио станцыг тус тус суурилуулах ба тохируулгын ажлыг талууд хамтран гүйцэтгэнэ.

5.6. Монголын талын төмөр зам утасгүй TETRA дижитал систем, Хятадын талын Ганцмод-Ваньшуйчуань төмөр зам 450MHz утасгүй галт тэрэгний диспетчерийн системийг ашиглана Хоёр талын зүтгүүрт эдгээр системтэй нийцэх зүтгүүрийн радио болон гар станцуудыг суурилуулах бөгөөд машинист нар өөр өөрсдийн нутаг дэвсгэртээ тухайн улсынхаа ашиглаж буй утасгүй системээр өртөөний жижүүртэй холбогдож, харин харилцан хил нэвтрэсний дараа нөгөө талын улсын утасгүй радио станцаар нөгөө улсын өртөөний жижүүртэй харилцана. Монголын тал өргөн царигийн зүтгүүрт утасгүй галт тэрэгний радио станцуудыг худалдан авч суурилуулахыг хариуцах бөгөөд тохируулах ажлыг Хятадын талтай хамтран гүйцэтгэнэ. Хятадын тал нарийн царигийн TETRA төхөөрөмжийг худалдан авч суурилуулахыг хариуцах бөгөөд тохируулгын ажлыг Монголын талтай хамтран гүйцэтгэнэ.

5.7. Гашуунсухайт өртөө болон Ганцмод өртөөдөд гол тоолох системийг суурилуулж, түүний тусламжтайгаар хоёр талын хилийн өртөөдөд

мэдээлэл нь хянагддаг байна. Хоёр улсын гол тоолох төхөөрөмж нь зөвхөн тухайн хэсэгт хөдлөх бүрэлдэхүүн байгаа эсэх талаарх мэдээллийг талуудад харуулна.

5.8. Гашуунсухайт өртөө болон Ганцмод өртөө хооронд галт тэрэг болон галт тэрэгний цуваатай холбоотой мэдээлэл /үүнд хөдлөх бүрэлдэхүүний төрөл, түүний дугаар, тогтмол үзлэгийн мэдээлэл гэх мэт/, мөн ачаатай холбоотой мэдээлэл /ачааны ангилал, ачааны даац жин, чингэлгийн төрөл, чингэлгийн дугаар, ачаа илгээгч, ачааны бичиг баримт гэх мэт/-ийг харилцан хуваалцаж байна.

#### 6 дугаар зүйл. Гүйцэтгэгч талын баталгаажуулалт

6.1. 2024 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн "Гашуунсухайт-Ганцмод босмтын хил дамнансан төмөр замын гүүрийг хамтран барих тухай хэлэлцээр"-ийг үндэслэн Хятадын талын хил дамнансан төмөр замын гүүрийн барилгын ажлыг гүйцэтгэх байгууллага болох "Чайна Энержи хөрөнгө оруулалт групп" ХХК нь "Чайна Энержи Ганцмод төмөр замын хөрөнгө оруулалт" ХХК-ийг байгуулсан бөгөөд тус компани нь Хятадын талын хил дамнансан төмөр замын төслийн хөрөнгө оруулалт, хөгжүүлэлт, бүтээн байгуулалт, ашиглалт болон дараагийн хөрөнгийн бүтцийн өөрчлөлт, нэгтгэл зэрэг холбогдох ажлыг хариуцна.

6.2. Ганцмод төмөр замын компани нь Хятадын хил идэвхрэх барилгын ажлыг гүйцэтгэх компанийн Тендерт шалгарсан тухай мэдэгдэл зэрэг холбогдох материалыг Тавантолгой төмөр зам компанид хүргүүлнэ.

6.3. Тавантолгой төмөр зам компани нь Монголын хил идэвхрэх барилгын ажлыг гүйцэтгэх компанийн Тендерт шалгарсан тухай мэдэгдэл зэрэг холбогдох материалыг Ганцмод төмөр зам компанид хүргүүлнэ.

#### 7 дугаар зүйл. Бусад

7.1. Төслийн хамтын ажиллагааг аль болох хурдан урагшлахуулахын тулд Монгол, Хятад хоёр тал тус тусдаа төмөр замын Ажлын хэсэг

7.6. Талууд нь хил холболтын төмөр замын бүтээн байгуулалтын өөр өөрийн хариуцах хэсэгт чанарын хяналтыг тавих бөгөөд хил холболтын хэсэгт чанарын хяналтыг хамтран тавина.

7.7. Энэхүү хэлэлцээр нь талуудын хууль ёсны төлөөлөгч эсхүл итгэмжлэлээр эрх олгогдсон этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болж, хил холболтын төмөр замын бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэх болон энэ төсөлтэй холбоотой хоёр улс хоорондын гэрээ, хэлэлцээр, санаамж бичигт дурдсан хугацаанд хүчинтэй байна.

7.8. Талууд энэ хэлэлцээрт тусгаагүй болон бусад асуудлаар нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба уг нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, талуудын хууль ёсны төлөөлөгч эсхүл итгэмжлэлээр эрх олгогдсон этгээдүүдийн гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулна. Оруулсан нэмэлт, өөрчлөлт нь энэ хэлэлцээрийн салшгүй хэсэг байна.

7.9. Энэхүү хэлэлцээрийн аль нэг заалт нь давагдашгүй хүчин зүйлийн улмаас хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд энэ нь хэлэлцээрийн бусад заалтуудын хэрэгжилтэд нөлөөлөхгүй.

7.10. Энэ хэлэлцээрийг хэрэгжүүлэх явцад аливаа өөрчлөлт өрсөн тохиолдолд нэг тал нь тухайн нөхцөл байдлыг бичгээр 10 хоногийн өмнө нөгөө талдаа мэдэгдэнэ.

7.11. Талууд барилгын ажлыг албан бичгээр харилцаж, тохиролцсоны үндсэн дээр эхлүүлнэ.

7.12. Энэхүү хэлэлцээрийг Хятад, Монгол, Англи хэл дээр 2 эх хувь үйлдэх бөгөөд тус бүр нэг нэг хувийг хадгална. Хэлэлцээрийн орчуулга зөрчилдсөн тохиолдолд Англи хэл дээрх хувилбарыг баримтална.

байгуулж, холбогдох асуудлыг чиглүүлж, зохицуулан шийдвэрлэж ажиллах ба хоёр талын Ажлын хэсэг нь ажлын шаардлагад үндэслэж зохих хурлыг зохион байгуулж, өөрсдийн ажлын явц, байдлыг харилцан мэдээлж, дараагийн шатны ажлын төлөвлөгөөг хэлэлцэнэ. Хятадын талын ажлын хэсгийг нь Ганцмод төмөр замын компани, Монголын талын ажлын хэсгийг Тавантолгой төмөр зам компани хариуцна. Хил дамнасан төмөр замын гүүрийг барих явцад үүссэн маргааныг хоёр талын ажлын хэсгүүд найрсаар харилцан зөвшилцөх хэлбэрээр шийдвэрлэнэ.

7.2. Төслийн бүтээн байгуулалтыг илүү сайн хэрэгжүүлэхийн тулд барилга угсралтын компанийг талбайд орохоос өмнө хоёр тал тухайн талбайг бодитоор эзэмших, өөрөөр хэлбэл барилгын газрыг ашиглах эрх зөвөл өмчлөх эрхийг авсан байх шаардлагатай бөгөөд Засгийн газрын барилга угсралтын зөвшөөрлийг авч, газрыг хугацаанд нь хүлээлгэн өгсөн байна. Барилгын ажил эхлэх хугацаа болон ажил гүйцэтгэх хугацаа нь ажлын эхлүүлэх мэдэгдэлд хүргүүлсэн өдрөөс тооцогдож эхэлнэ.

7.3. Талууд нь хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд тухайн бүс нутаг дэвсгэртээ барилга угсралтын ажлыг саадгүй явуулахын тулд барилгын ажлын гүйцэтгэгч компанид ажил гүйцэтгэхэд тохирох нөхцөлийг бүрдүүлэх талаар шаардлагатай дэмжлэгийг үзүүлж хамтарч ажиллана.

7.4. Талууд нь барилгын компанид шаардлагатай техникийн дэмжлэг үзүүлэх бөгөөд үүнд геологийн судалгааны мэдээлэл, орон нутгийн барилгын техникийн нөхцөл, техникийн стандарт болон барилгын явцад гарсан техникийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.

7.5. Талууд нь өөрийн улсын нөхцөл байдал, дүрэм журмын дагуу шаардлагад нийцсэн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, онцгой байдлын төлөвлөгөө, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэхэд барилгын ажлын гүйцэтгэгч компанитай уялдаа холбоотой ажиглалт.


11 24

11 24

ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"ЧАЙНА ЭНЕРЖИ ГАНЦМОД ТӨМӨР  
ЗАМЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ" ХХК


"ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ" ХХК



---



---



CONTRACT FOR THE CONSTRUCTION OF THE CROSS-BORDER  
RAILWAY OF THE GASHUUNSUKHAIT-GANTSMOD PORT

between

TAVANTOLGOI RAILWAY LLC

and

CHINA RAILWAY CONSTRUCTION BRIDGE ENGINEERING BUREAU  
GROUP CO., LTD.

ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК

болон

ХЯТАДЫН ТӨМӨР ЗАМЫН БАРИЛГЫН ГҮҮРИЙН ИНЖЕНЕРИЙН  
ТОВЧОО ГРУПП ХХК

хооронд байгуулсан

ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД БООМТЫН ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР  
ЗАМЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

塔本陶勒盖铁路有限公司与中国铁建大桥工程局集团  
有限公司关于建设嘎舒苏海图-甘其毛都口岸跨境铁路  
建设项目合同

Date: 2025.06.09

Огноо: 2025.06.09

日期: 2025年6月9日

Mongolia  
Монгол Улс  
蒙古国

Employer

Contractor

## DOCUMENTS INCORPORATED INTO AND FORMING PART OF THE CONTRACT

1. **PART I – Contract Agreement, Amendments and Modifications** (*if any*)
2. **PART II – General Conditions**  
FIDIC Conditions of Contract for Construction (Red Book), 2017 Edition with 2022 Amendments
3. **PART III – Particular Conditions**  
Part A: Contract Data  
Part B: Special Provisions
4. **ANNEXES**  
Annex 1: Minutes of the Meeting on Agreement Terms Negotiation dated 2025.06.09  
Annex 2: Performance Security and Advance Payment Guarantee  
Annex 3: Work Schedule  
Annex 4: Priced of Bill of Quantities  
Annex 5: Approvals and Licenses of the Contractor and the Employer (*including special permits, certificates, and authorizations for signing from the Parties' Boards of Directors and shareholders*)  
Annex 6: Responsibility Matrix Required for Contract Implementation  
Annex 7: Health, Safety, and Environmental Requirements  
Annex 8: Insurance Certificates

### ГЭРЭЭНИЙ ИЖ БҮРДЭЛД ОРЖ БУЙ БИЧИГ БАРИМТУУД

1. **ГЭРЭЭНИЙ I ХЭСЭГ** – Гэрээний Хэлэлцээр, Нэмэлт, Өрчлөлтийн Гэрээ (*Хэрэв Байгаа Бол*)
2. **ГЭРЭЭНИЙ II ХЭСЭГ** - Ерөнхий Нөхцөл  
ФИДИК холбооноос гаргасан Захиалагчийн зураг төслөөр ажил гүйцэтгэх гэрээ, 2022 онд нэмэлт өөрчлөлт оруулсан 2017 нөхцөлүүд. (Улаан ном)
3. **ГЭРЭЭНИЙ III ХЭСЭГ - ТУСТАЙ НӨХЦӨЛ:**  
А хэсэг: Гэрээний өгөгдөл  
Б хэсэг: Тусгай заалтууд
4. **Хавсралтууд**  
Хавсралт 1. Гэрээний нөхцөлийг тохиролцсон хурлын 2025.06.09 өдрийн протокол  
Хавсралт 2. Гүйцэтгэлийн баталгаа, Урьдчилгаа төлбөрийн баталгаа  
Хавсралт 3. Ажлын төлөвлөгөө  
Хавсралт 4. Ажлын тоо хэмжээ, төсөвт өртгийн зарларгаа  
Хавсралт 5. Гүйцэтгэгчийн болон Захиалагчийн зөвшөөрлүүд (*тусгай зөвшөөрөл болон бусад зөвшөөрлүүд, гэрчилгээ, мөн Талуудын ТУЗ болон хувьцаа эзэмшигчийн гэрээг зурах зөвшөөрлүүд*)  
Хавсралт 6. Гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах үүргийн матриц

## 合同组成文件：

1. 第一部分 - 合同协议书，补充修改合同（如果有）
2. 第二部分 - 通用条款  
FIDIC出版的施工合同条件，2017年版（红皮书），2022年进行了补充修订；
3. 第三部分 - 特殊条款  
A部分：合同数据  
B部分：特别规定
4. 附件  
附件 1：2025 年 6 月 9 日关于协议条款谈判的会议纪要  
附件 2：履约保函和预付款保函  
附件 3：工作计划  
附件 4：标有价格的工程量清单  
附件 5：承包商和雇主的批准及许可证（包括特殊许可、证书以及双方董事会和股东的授权签署文件）  
附件 6：合同实施所需的责任矩阵  
附件 7：健康、安全与环境要求  
附件 8：保险证书

5-05

BAB  
GME  
X

1192  
JHEA  
X



Employer

- 2 -



Contractor

## I. CONTRACT AGREEMENT

This Contract Agreement is made and enter into this 2025, by and between the following parties:

**Party A:** "Tavantolgoi Railway" LLC, a company established under the laws of Mongolia, with its principal office located at Union Building B Block, 11th floor, Narnii Zam-62, 13th khoroo, Sukhbaatar District, Ulaanbaatar, Mongolia, represented by B.Dugerjav, Acting Chief Executive Officer, (hereinafter referred to as the "Employer"), and

**Party B:** China Railway Construction Bridge Engineering Bureau Group Co., Ltd., a company established under the laws of the People's Republic of China, with its principal office located at No. 32, West Zhonghuan Road, Pilot Free Trade Zone (Airport Economic Area), Tianjin, represented by Li Guoqiang, member of Board of Director (hereinafter referred to as the "Contractor");

(collectively referred to as the "Parties").

## I. ГЭРЭЭНИЙ I ХЭСЭГ – ГЭРЭЭНИЙ ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү гэрээний хэлэлцээрийг 2025 оны 06 дугар сарын 09-ний өдөр дор дурдсан талууд харилцан тохиролцож байгуулав.

**А тал:** Монгол Улс, Улаанбаатар хот 14230, Сүхбаатар дүүрэг, 13-р хороолол, Нарны зам-62, Юнион Бюлдинг Б блок, 11 давхар хаягт байрлах, Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, "Тавантолгой төмөр зам" ХХК (цаашид "Захиалагч" гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Дүгэржав,

**Б тал:** Тяньжин хот, Кунган эдийн засгийн бүс, Жунхуан баруун зам 32 тоот хаягт байрлах, БНХАУ-ын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан "Хятадын төмөр замын барилгын гүүрийн инженерийн товчоо групп" ХХК (цаашид "Гүйцэтгэгч" гэх ) нар нь (Хамтад нь "Талууд" гэх), түүнийг төлөөлж Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Ли Гуочянь.

## 合同第一部分 – 合同协议书

本合同协议书于2025年6月9日由下列双方签订:

**甲方:** 蒙古国, 乌兰巴托市14230号, 苏赫巴托区, 第13号街区, 纳尔恩大街62号, 联合大厦B座11层, 根据蒙古国法律成立的"塔本陶勒盖铁路"有限公司 (以下简称"雇主"), 由代理执行CEO杜格尔扎布代表;

**乙方:** 注册地址为天津市空港经济区中环西路32号, 依据中国法律成立的中国铁建大桥工程局集团有限公司 (以下简称"承包商"), 由董事李国强代表;

以下统称为"双方")

## SECTION I. GENERAL PROVISIONS

The Parties have based this Agreement on the following legal instruments:

- The Memorandum of Understanding signed in August 2022 between the Ministry of Finance and the Ministry of Road and Transport Development of Mongolia and the National Development and Reform Commission of the People's Republic of China regarding the

Gashuunsukhait–Gantsmod Border Port Cross-Border Railway;

- Resolution No. 68 dated July 7, 2023, of the State Great Khural (Parliament) of Mongolia;
- Resolutions No. 310 dated August 23, 2023, No. 156 dated March 26, 2025, and No. 176 dated April 9, 2025, of the Government of Mongolia;
- The Agreement between the Government of Mongolia and the Government of the People’s Republic of China on the Joint Construction of the Gashuunsukhait–Gantsmod Border Port Cross-Border Railway Bridge, signed on April 2, 2024;
- The Agreement on Cooperation for the Gashuunsukhait–Gantsmod Border Port Cross-Border Railway, Coal Trade, and Capacity Expansion of the Tavantolgoi Coal Mine, signed between the Government of Mongolia and the Government of the People’s Republic of China on February 14, 2025;
- Resolution No. 58 dated December 27, 2024, of the State Great Khural of Mongolia, “On Approving the Basic Guidelines for Concluding the Agreement between the Government of Mongolia and the Government of the People’s Republic of China on the Implementation of the Cross-Border Railway Construction at Gashuunsukhait–Gantsmod Border Port”;
- The Agreement on the Construction of the Gashuunsukhait–Gantsmod Cross-Border Railway signed on May 14, 2025, between Tavantolgoi Railway LLC and China Energy Gantsmod Railway Investment LLC;
- The Temporary Regulation to be followed within the “Closed Construction Zone” for the Joint Construction of the Cross-Border Railway Bridge at the Gashuunsukhait–Gantsmod Border Port between Mongolia and China;
- Notification No. A-1/1752 dated May 2, 2025, from the Director of the Public Procurement Agency of Mongolia regarding the granting of the right to conclude the contract.

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**Талууд дараахь эрх зүйн баримт бичгийг үндэслэл болгов. Үүнд:**

- Монгол Улсын Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Үндэсний хөгжил, шинэчлэлийн хороо хооронд 2022 оны 08 дугаар сард байгуулагдсан Гашуунсухайт-Ганцмод боомтын хил холболтын төмөр замын тухай харилцан ойлголцлын санамж бичиг;
- Монгол Улсын Их Хурлын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 68 дугаар тогтоол;
- Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 310 дугаар, 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 156 дугаар, 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 176 дугаар тогтоол;
- Монгол Улсын засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр байгуулагдсан Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын гүүрийг хамтран барих тухай хэлэлцээр;
- Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр байгуулагдсан “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам нүүрсний худалдаа, тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны хэлэлцээр”;
- Монгол Улсын Их хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 58 дугаар “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд

Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” тогтоол;

- “Тавантолгой төмөр зам” ХХК болон “Чайна энержи ганцмод төмөр замын хөрөнгө оруулалт” ХХК нарын хооронд 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр байгуулагдсан “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам барих тухай хэлэлцээр”-ийг;

- Монголын, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын гүүрийг хамтран барих “бүтээн байгуулалтын хаалттай бүс”-д мөрдөх түр журам,

- Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А-1/1752 дугаар “Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл” хүргүүлснийг тус тус үндэслэв.

## 1. 总则

各方依据以下法律文件：包括：

- 《蒙古国政府和中华人民共和国政府关于共同建设嘎舒苏海图至甘其毛都口岸跨境铁路桥的协定》，2024年4月2日签署；

-2022年8月，蒙古国财政部、道路运输发展部与中华人民共和国国家发展和改革委员会签署了《关于嘎舒苏海图至甘其毛都口岸跨境铁路连接谅解备忘录》。

-蒙古国家大呼拉尔2023年7月7日第68号决议；

-蒙古政府2023年8月23日第310号决议、2025年3月26日第156号决议、2025年4月9日第176号决议；

-2025年2月14日，蒙古国政府与中华人民共和国政府签署《关于嘎舒苏海图至甘其毛都口岸跨境铁路、煤炭贸易、塔旺陶勒盖煤矿产能扩建项目的合作协议》；

-2024年12月27日蒙古国会第58号决议《关于批准蒙古国政府和中华人民共和国政府关于实施嘎舒苏海图至甘其毛都口岸跨境铁路建设的协定的基本指导方针》；

各方依据2025年法律文件：签署了《关于建设嘎舒苏海图至甘其毛都口岸跨境铁路的协议》；

-在蒙古和中国边境的嘎舒苏海图至甘其毛都口岸跨境铁路桥联合建设的“施工禁区”内实行临时规定；

-根据国家采购部主任于2025年5月2日发布的第A-1/1752号“授予签订合同权的通知”。

Whereas the Employer has invited the Contractor to bid for the construction project of the cross-border railway between Gashuunsukhait and Ganqimaodu Port in Mongolia (hereinafter referred to as the "Project"), and the Contractor has submitted its bid for the Project on April 30, 2025, and the Employer has received the bid submitted by the Contractor and issued a letter of acceptance to the Contractor. Therefore, the two parties hereby reach the following agreements:

Захналагч нь Гүйцэтгэгчийг Монгол Улсын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын төсөл (цаашид “Төсөл” гэх)-ийн тендерт оролцохыг урьсан бөгөөд Гүйцэтгэгч 2025 оны 4-р сарын 30-ны өдөр тендерийн бичиг

5

Employer

Contractor

баримтаа ирүүлж, Захиалагч Гүйцэтгэгчийн тендерийн бичиг баримтыг хүлээн авч, тендерт шалгарсан тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлснээр талууд дараах тохиролцоонд хүрэв.

鉴于雇主邀请承包方对蒙古国嘎舒苏海图-甘其毛都口岸跨境铁路建设项目（以下简称项目）进行投标，承包方于2025年4月30日提交了该项目投标书，雇主接收承包方的投标书，并向承包方发出中标通知书，为此，双方达成下列协议。

## 2.SCOPE OF WORK TO BE UNDERTAKEN BY THE CONTRACTOR:

Under this Contract, the Parties agree to carry out the construction work of the Gashuunsukhait-Gantsmod cross-border railway, including the following packages:

- Package 1: Railway superstructure and substructure;
- Package 2: Viaduct bridge;
- Package 3: Power supply systems;
- Package 4: Construction Works;
- Package 5: Signaling and Communication;
- Package 6: Road Works;
- Package 7: Some equipment (excluding rolling stocks);
- Package 8: Standardization /Approval of foreign standards as national standards of Mongolia/.

## ХОЁР. ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ЦАР ХҮРЭЭ


Энэхүү гэрээгээ Гүйцэтгэгч нь Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын барилгын ажлыг гүйцэтгэнэ. Тус төсөл нь дараах 8 багц ажлаас бүрдэнэ.

- Багц 1. Төмөр замын дээд, доод бүтэц;
- Багц 2. Эстакадан гүүр;
- Багц 3. Эрчим хүч;
- Багц 4. Барилга байгууламж;
- Багц 5. Дохиолол холбоо;
- Багц 6. Авто зам;
- Багц 7. Тоног төхөөрөмжийн бүрэлдэхүүн, (зүтгүүр багтаагүй);
- Багц 8. Стандарт /Гадаадын стандартыг Монгол Улсын үндэсний стандарт болгон батлуулах/.


## 2.承包商实施的工作范围:

根据本合同，承包商将承担嘎舒苏海图-甘其毛都口岸跨境铁路工程的实施工作，包括以下八个项目包:

- 包1: 铁路的上、下部结构;
- 包2: 高架桥;

  
Employer

6

  
Contractor

- 包3: 电力工程;
- 包4: 建筑设施;
- 包5: 信号与通信;
- 包6: 公路工程;
- 包7: 部分设备 (不包含机车车辆);
- 包8: 标准化 (将国外标准转化为蒙古国国家标准)。

### 3.CONTRACT DOCUMENTS

The documents forming the contract are to be taken as mutually explanatory of one and the other. In case of any conflict, ambiguity or inconsistency, the priority of the documents shall be as follows:

- (a) Contract Agreement and any Amendments or Modifications (if applicable);
- (b) Minutes of the Meeting on the Agreement Terms Negotiation /2025.06.09/;
- (c) The letter of acceptance;
- (d) The letter of tender;
- (e) Particular Conditions – Part A: Contract Data;
- (f) Particular Conditions – Part B: Special Provisions and Clauses;
- (g) General Conditions of Contract (FIDIC Conditions of Contract for Construction , 2017 Edition with 2022 Amendments – Red Book);
- (h) Contractor’s Tender Documents and Attachments;
- (i) Technical Specifications and Requirements;
- (j) Drawings and Designs;
- (k) Priced Bill of Quantity;
- (l) Work Schedule;
- (m) Health, Safety, and Environmental Requirements;
- (n) Other Documents Constituting Part of the Contract.

### ГУРАВ. ГЭРЭЭНИЙ БАРИМТ БИЧГИЙН ЭРЭМБЭ

Энэхүү гэрээний хэлэлцээрийг бүрдүүлж буй дараах баримт бичгүүд нь харилцан уялдаатайгаар нэг нь нөгөө бичиг баримтаа тайлбарлах бөгөөд элгээр баримт бичиг хооронд аливаа зөрчил, тодорхойгүй, зөрүүтэй байдал гарсан бол Гэрээний хэлэлцээрийн баримт бичгийн эрэмбэ нь дараах байдлаар тайлбарлагдана.

- (a) Гэрээний хэлэлцээр болон бусад нэмэлт өөрчлөлт (хэрэв байгаа бол);
- (b) Гэрээний нөхцөлийг тохиролцсон хурлын протокол /2025.06.09/;
- (c) Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- (d) Гүйцэтгэгчийн тендерт ирүүлсэн санал;
- (e) Гэрээний Тусгай нөхцөл А хэсэг- Гэрээний өгөгдөл;
- (f) Гэрээний Тусгай нөхцөл Б хэсэг-Тусгай нөхцөл, заалт;
- (g) Гэрээний ерөнхий нөхцөл (ФИДИК холбооноос гаргасан Захиалагчийн зураг төслөөр ажил гүйцэтгэх гэрээ, 2022 онд нэмэлт өөрчлөлт оруулсан 2017 нөхцөлүүд. (Улаан ном);

Employer

Contractor

- (h) Тендерийн бичиг баримт болон хавсралтууд;
- (i) Техникийн тодорхойлолт ба шаардлага;
- (j) Зураг төсөл;
- (k) Гэрээний үнэ, ажлын тоо хэмжээ;
- (l) Ажлын төлөвлөгөө;
- (m) ХАБЭА болон Байгаль орчны шаардлага;
